

## ХЭСЭГ С: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

### С12: ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

#### Агуулга

12. ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ .....	2
12.1 ТАНИЛЦУУЛГА.....	2
12.2 ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ .....	2
12.2.1 Орон зайн хамрах хүрээ .....	2
12.2.2 Цаг хугацааны хамрах хүрээ .....	2
12.3 НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	2
12.3.1 Нөлөөллийн тухай хураангуй.....	2
12.3.2 Зам тээврийн аюулгүй байдал ба нэмэгдэж буй замын хөдөлгөөний ослууд.....	3
12.3.3 Төслөөс үүдэлтэй Аюул Эрсдэлд Олон Нийт Өртөх.....	6
12.3.4 Халдварт өвчний нэмэгдсэн тохиолдлууд .....	7
12.3.5 Хамгаалалтын албыг байршуулах.....	9
12.3.6 Хувь Хүний Эрүүл Мэнд, Аюулгүй Ажиллагаа Доройтох .....	10
12.3.7 Барилгын болон ашиглалтын шатны үйл ажиллагаа олон нийтийн эрүүл мэндэд нөлөөлөх нь: Тоосжилт .....	16
12.3.8 Барилгын болон Ашиглалтын шат олон нийтийн эрүүл мэндэд нөлөөлөх нь: Дуу чимээ	
12.3.9 Барилгын болон Ашиглалтын Шатны үйл ажиллагаа Олон Нийтийн Эрүүл Мэндэд Нөлөөлөх: Усны хүртээмж болон усны чанар.....	18
12.4 ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ.....	18

#### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 12-1: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын нөлөөлөл 207

## 12 ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

### 12.1 ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОННБҮ) энэхүү бүлэг нь Оюу Толгой төслийн барилга, ашиглалт ба хаалтын үе шатны олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал /ЭМАААБ/-д үзүүлж болох нөлөөллийн талаар хэлэлцсэн. Энэ бүлэгт Төслийн аюул эрсдэл, үйл ажиллагааны улмаас олон үзүүлэх шууд нөлөөлөл болон хүн амын шилжилт хөдөлгөөнөөс үр дүнд олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд үзүүлэх шууд бус нөлөөллийн талаар авч үзэв.

Мөн энэ бүлэгт Оюу Толгойгоос зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр орон нутгийн иргэдээс дэвшүүлсэн асуудлуудыг мөн тусгасан. Төсөл нь нэгэнт барилгын ажлын ахисан шатанд явж байгаа тул зарим нөлөөллүүд нэгэнтээ бий болсон бөгөөд холбогдох бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Урт хугацааны менежмент, хяналт шинжилгээний арга хэмжээний талаар *Бүлэг D18: Олон нийтийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө*-д тусгасан болно.

### 12.2 ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

#### 12.2.1 Орон зайн хамрах хүрээ

Үнэлгээг төсөл хэрэгжиж буй Ханбогд сумын хэмжээнд хийж боловсруулсан. Гэвч төслийн ерөнхий цар хүрээний дагуу нөлөөлөл нь Төслийн нөлөөллийн бүсийн бусад хэсэгт илрэх магадлалтай юм (тухайлбал: Манлай, Баян-Овоо, Даланзадгад, Цогтцэций сумууд).

#### 12.2.2 Цаг хугацааны хамрах хүрээ

Цаг хугацааны хамрах хүрээний хувьд барилгын ажлын үе шат, ашиглалтын үе шат болон хаалтын үе шатуудыг хамруулсан.

### 12.3 НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

#### 12.3.1 Нөлөөллийн тухай хураангуй

Барилгын ажлын, ашиглалтын болон хаалтын үе шатуудад ЭМАБХ-н хувьд дараах нөлөөллүүдийг үзүүлэх төлөвтэй байна:

- Төслийн талбайгаас Хятадын хил хүртэлх баяжмал зөөвөрлөх авто зам, төслийн талбайн орж гарах замууд, Оюу Толгой болон Ханбогд сумын төвийг холбосон авто зам зэрэгт замуудын ашиглалттай холбоотойгоор замын хөдөлгөөний аюул, аваар осол нэмэгдэх эрсдэл;
- Төслийн барилгын ажлын, ашиглалтын болон хаалтын үе шатны үйл ажиллагаатай холбоотой аюул эрсдэлд өртөх;
- Халдварт өвчний тохиолдол ихсэх;
- Одоогийн байгаа суурь хэмжээг нэмэгдүүлэх буюу шинэ нөхцөл байдал бий болгож болошгүй тоосжилттой холбоотой орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл (жишээлбэл, амьсгалын замын, нүдний, арьсны өвчлөлүүд);
- Төслийн талбайд (Уурхайн лицензит талбай дотор) болон талбайгаас гаднах үйл ажиллагааны (олон нийтэд зохион байгуулж буй) үед хамгаалалтын албатай холбоотой үүсэх эрсдэл;
- Хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хувийн аюулгүй ажиллагаа ба эрүүл мэндтэй холбоотой нөлөөллүүд;

Дараах хэсэгт эдгээр гарч болох бүх нөлөөллүүдийг шинж чанар, бодит болон төлөвлөж буй нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, бууруулсны дараахь үлдэгдэл нөлөөлөл зэргийг авч үзэх болно. Үүнийг нэгтгэсэн хүснэгтийг (Хүснэгт 12.1) энэ бүлгийн эцэст оруулав

### **12.3.2 Зам тээврийн аюулгүй байдал болон нэмэгдэж б зам**ын хөдөлгөөний ослууд

#### ***Нөлөөллийг тодорхойлох нь***

Оюу Толгой төсөл нь Монголын Өмнийн Говийн Бүсийн хүн ам сийрэг суурьшсан суманд байрладаг. Сумын хэмжээнд авто замын ихэнх нь шороон (өөрөөр хэлбэл хатуу хучилт буюу асфальтан хучилтгүй) зам байна. Замын сайжруулалт хийгдсэн газар нь гагцхүү хайрга шороог нягтруулах замаар хийгдсэн байдаг. Аймаг, орон нутгийн засаг захиргаа замын сайжруулалт хийх хангалттай нөөц боломжгүйгээс тус сумын замыг сайжруулах ажлыг гагцхүү Оюу Толгой (уурхайн талбайгаас Ханбогд хүртэлх зам, мөн Ханбогдоос Манлай сум хүртэлх авто зам) болон Энержи Ресурс (нүүрс тээвэрлэх зам) компаниуд гүйцэтгэсэн.

Барилгын ажлын явцад бараа материалыг Оюу Толгой - Гашуун Сухайт чиглэлийн замаар Гашуун Сухайтын хилийн боомтоор дамжуулан Хятадаас Оюу Толгойн талбайд хүргэх юм. Энэ нь Ханбогд сумаар дайран өнгөрөх одоо ашиглагдаж буй 100 км орчим үргэлжилсэн зам бөгөөд Оюу Толгой нь 2012 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэйгөөр өндөр зэрэглэлийн давхар хучилттай зам болгон сайжруулж байна. ОТ-ГС-ын замын (Оюу Толгойд хамаатай тээврийн хэрэгслийг оруулаад бүх тээврийн хэрэгслийн<sup>1</sup>) хөдөлгөөний одоогийн ачаалал нь (2011 онд) өдөрт дунджаар 143 хүнд даацын ачааны машин, 108 хөнгөн тэрэгний хөдөлгөөн явагддаг гэж бүртгэгдсэн байна. *(Бүлэг В11 Тээвэр ба дэд бүтэц-ийг харна уу)*

Үйл ажиллагааны 4 дэх жилд олборлолтын явцад Оюу Толгой -Гашуун Сухайтын замаар явагдах баяжмалын тээвэрлэлт нь хоногт ойролцоогоор 80 хүртэлх тооны ачаа эргэлт (өдрийн ажлын цагаар ойролцоогоор цагт 8 ачааны машин) болно. Энэ нь Оюу Толгой руу хоосон буцаж байгаа машинуудыг оруулбал, өдөрт ойролцоогоор 160 машин эргэлт гарна гэсэн үг юм. Оюу Толгой-Гашуун Сухайтын замын (уг замыг барьж дууссаны дараа бусад замуудаас орж ирэх дамжих урсгал болон Оюу Толгой, Таван Толгойн төслүүд хэрэгжиж эхэлснээс хойш үүсэх хөдөлгөөн зэргийг оруулаад) ирээдүйн замын хөдөлгөөний тоо хэмжээний тооцооллоор 2011-2015 оны хугацаанд (тухайлбал, барилгын ажлын оргил үед буюу олборлолт явуулах эхний хугацаанд) замын хөдөлгөөн 19%-иар ихсэх бөгөөд төсөл үйл ажиллагаа тогтвортой түвшинд хүрэх үед өсөлт аажмаар 12% хүртэл буурна гэдгийг харуулж байна.

Тээвэрлэлтийг голчлон аюулгүйн ажиллагааны зорилгоор аль болох өдрийн цагаар төлөвлөх боловч энэ нь шөнийн цагт дуу чимээг бууруулах давхар ач холбогдолтой юм.

Хилийн дамжин өнгөрөх гаалийн боомт нь зөвхөн идэвхгүй бодисыг шинжлэн тодорхойлох боломжтой бөгөөд үүний улмаас Хятадаас болон өөр хаа нэгтээгээс орж ирж байгаа аливаа аюултай бодисыг Транс-Монголын төмөр замаар дамжуулан Улаанбаатарт авчирч шинжлүүлэх шаардлагатай. Энэхүү Улаанбаатар хотоос Оюу Толгой хүртэл тээвэрлэгдэж байгаа аюултай бодисын ачаа барилгын талбай хүрэх замдаа Чойр, Манлай сумуудыг дамжин өнгөрдөг. Төсөлд нийлүүлэх шатахууныг Транс-Монголын төмөр замын ойролцоох УЛТ-аас зүүн тийш орших агуулахаас цистернээр тээвэрлэн ирнэ.

Оюу Толгой, Ханбогд, Манлай сумд хоорондын бараа материал хангамж тээвэрлэлтийн замын одоогийн (2011 онд<sup>2</sup>) хөдөлгөөний хувьд хоногт дундажаар 178 хүнд даацын тээврийн хэрэгсэл, 165 хөнгөн тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцож байна гэж бүртгэгдсэн. Эдгээрээс 140 орчим хүнд даацын тээврийн хэрэгсэл болон 38 хөнгөн тээврийн хэрэгслүүд нь Оюу Толгойд харъяалагдаж буйгаас үзэхэд төслийн үйл ажиллагаатээврийн хөдөлгөөнийг нэмэгдүүлсэн байна. Мөн төсөлтэй холбоотойгоор хүн амын шилжин ирж суурьших, эдийн засгийн үйл ажиллагаа идэвхих зэргийн үр дүнд орон нутгийн замуудын (тухайлбал, шороон замуудын) хөдөлгөөн нэмэгдэх юм.

<sup>1</sup> Оюу Толгойтой холбоотой тээврийн хэрэгслийн хөдөлгөөн энэ замд хүнд даацын машины 72%, хөнгөн тэрэгний 30 %-тай тэнцэнэ.

<sup>2</sup> Ibid, Тээврийн тооллого бүртгэл, 2011.

Оюу Толгой –Гашуун Сухайтын замыг сайжруулсанаар сумын иргэд хүнс бараа, үйлчилгээгээ авах зах зээлдээ хүрэх боломж илүү сайжрах тул зарим эерэг нөлөөллийг бий болгох юм. Мөн замын сүлжээ сайжрах нь нь малчин өрхүүд болон хөдөөгийн иргэд сумын төвийн эмнэлэгт хандах зэргээр зарим үйлчилгээнд хүрэх боломжийг нэмэгдүүлнэ. Олон тооны хатуу хучилтгүй замуудыг бодвол ганц, давхар хучилттай замыг ашигласнаар тоос шороо үүсэх явдал багасах нь хоёр дахь эерэг нөлөөлөл болж байна. Энэхүү эерэг нөлөө гагцхүү Оюу Толгой- Гашуун Сухайтын замын хучилт тавигдаж дууссаны дараа бодитой болж хэрэгжих юм. Барилгын ажлын үйл явцад тоосжилт ерөнхийдөө нэмэгдэхээр байна.

Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдэж, замын хөдөлгөөн ерөнхийдөө нэмэгдсэнээр хот суурин газрын болон хөдөөгийн иргэдийн аюулгүй байдалд ялангуяа зам малчдын өвөлжөө, хаваржаа, мөн хот айлд ойрхон дайрах газруудад эрсдлийг бий болгож байгаа юм. Ханбогд сумын ЗДТГ-аас гаргасан мэдээллээр Оюу Толгой төсөлд хамааралгүй тээврийн хэрэгслүүдийн холбогдсон замын хөдөлгөөний 9 осол 2009 онд, 2010 онд 8 осол бүртгэгдсэн байна<sup>3</sup>. Бүртгэгдсэн ослын тоо цөөн байгаа нь бусад олон осол бүртгэгдээгүй, хүн амын тоо цөөн зэрэгтэй холбоотой гэж үзэж байна. Оюу Толгой төслийн Олон нийтийн Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээний<sup>4</sup> хээрийн судалгаанд оролцогчид нь замын ослын улмаас гарч байгаа гэмтэл бэртэл ялангуяа Ханбогд суманд нэмэгдэж байгаа гэж үзсэн байна. Мөн судалгаанд оролцогчид мотоцикл эзэмших нь хурдацтай өсч байгаа бөгөөд үүнийг дагаад мотоциклтой холбоотой осол аваарийн тоо нэмэгдэж байна гэж тэмдэглэсэн.

Орон нутгийн иргэдийн үзэж байгаагаар дараах шалтаануудын улмаас замын хөдөлгөөний осол аваарын тоо нэмэгдэж байна. Үүнд:

- Замын хөдөлгөөний нийт хэмжээ ихээр нэмэгдсэн;
- Жолооч ядарсан байх;
- Тоос шороо гэх мэт (харагдах байдалд нөлөөлж буй) орчны хүчин зүйлээс;
- Архи согтууруулах ундаа хэрэглэх явдал ихэссэн;
- Замын чанар муу;
- Сайжруулсан замаар хурдтай явдаг;
- Зам барилгын ангийн үлдээсэн нүхнүүд.

Ялангуяа Ханбогд сумын малчид энэхүү шинэ замууд болон хүнд даацын машины нэмэгдсэн хөдөлгөөний нөлөөлөлд илүү өртөмтгий болж байгаа юм. Малчдын өвөлжөө төслийн хэд хэдэн замуудын дагуу байрлаж байгаа ба малчид малаа тууварлан худаг ус, бэлчээртээ хүрэхийн тулд ихэнхдээ ан амьтанд зориулсан гарцуудыг ашигладаг. (Бүлэг В10 Газар ашиглалт-г харна уу). Замууд малчдын өвөлжөө бууц, малын хашаа хороо, уст цэгийн ойролцоо дайран өнгөрч болзошгүй нь мал, хүмүүс аль алинд нь зам хөндлөн гарахад аюул учруулж байна. Малчид малаа тууварлан зам гарах үед ялангуяа үдшийн бүрэнхийд буюу шөнийн цагаар замаар хөндлөн гарахад аваар осол гарах эрсдэлтэй байна.

Түүнчлэн, Ханбогд болон бусад сумдад гэнэтийн онцгой байдалд хариу арга хэмжээ авах боломж хязгаарлагдмал (хариу арга хэмжээ авах хүмүүс, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж дутагдалтай); Оюу Толгойн ажлын талбайд түргэн тусламж үзүүлэх эмнэлгийн баг байдаг боловч малчдад түргэн тусламж үзүүлэх нөөц байхгүй. Иймд гарч болох аюул осолд хариу арга хэмжээ авах цаг хугацаа удаан байх төлөвтэй<sup>5</sup>.

Дээр өгүүлснээр Улаанбаатараас ирж байгаа хангамжийн тээвэрлэлтийн зам нь тодорхой суурин газруудаар дайрдаг учир эдгээр орон нутгийн иргэдийн хувьд замын хөдөлгөөний эрсдлийг нэмэгдүүлж байна. Хангамжийн зүйлсийг тээвэрлэж байх үед ямар нэгэн осол аваар гарах нь мөн

<sup>3</sup> Ханбогд сумын засаг даргын тамгын газраас Оюу Толгойд 2011 онд өгсөн мэдээ.

<sup>4</sup> Оюу Толгой төслийн Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх байдлын байдлын үнэлгээ, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум, 2011, (хээрийн судалгааг 2010 онд явуулсан).

<sup>5</sup> Оюу Толгой төслийн Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум, 2011, (хээрийн судалгааг 2010 онд явуулсан).

ашиглалтын химийн бодис ба/буюу аюултай бодис материал гадагш алдагдахад хүргэж болно. Мөн тээврийн хэрэгслийн жолооч нар хог хаягдал, дугуй, бензин тосоо замын дагуу хаяж байгаа тухай мэдээлэл байгаа бөгөөд энэ нь бусад зам ашиглагчид, малчид, ургамал, амьтанд муугаар нөлөөлж болно <sup>6</sup>.

### **Нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Оюу Толгой төсөл нь одоо байгаа Оюу Толгой-Гашуун Сухайтын замыг сайжруулан хатуу хучилттай болгох ажлыг 2013 онд дуусгахаар ажиллаж байна. Энэ нь замын тогтсон чиглэлийг гаргаж өгөх, олон зам гаргах, тоос шороо үүсэх явдлыг бууруулах бөгөөд энэ зам нь таамагдаж буй замын хөдөлгөөний ачаалал ба машины хэмжээнд (багтаамж, ачааны даацын хувьд) тохирно хэмээн тооцоолж байна.

Мөн Оюу Толгой нь Оюу Толгойгоос Ханбогд сум орох зам гэх мэт төслийн голчлон ашиглаж байгаа бусад замуудыг засварлаж арчлахад хувь нэмрээ оруулах болно. Энэхүү замыг ажилчид төслийн талбай болон Ханбогд сумын хооронд зорчиход сэлгэж ашигладаг бөгөөд Оюу Толгой нь энэхүү замыг 2012 онд сайжруулахаар төлөвлөж байна.

*Бүлэг А6: Орон нутгийн иргэдтэй хийх хэлэлцүүлэг*-т дурдсанчлан малчид зам хөндлөн гарах аюулгүй гарцын байршил, амьтан гарах гарцуудыг тогтоох, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зүйлс тухайлбал, аюулгүйн тэмдэглэгээ, хурдны хязгаар зэрэг замын аюулгүй байдлын зохицуулах арга хэмжээнүүдийг тогтоох үүднээс малчин өрхүүдтэй өргөн хэмжээний хэлэлцүүлэг явуулсан. Энэхүү аюулгүй байдлын талаар авах арга хэмжээ нь одоо Оюу Толгой-Гашуун Сухайтын замын зураг төслийн нэг бодит хэсэг болсон <sup>7</sup>.

Ханбогд сумын замууд Оюу Толгой - Гашуун Сухайтын замтай огтлолцож байгаа газруудад замын уулзваруудыг барьж байгуулах ба зөв замыг тодорхой заах замын тэмдэглэгээнүүдийг хийх юм. Замын уулзваруудыг байгуулснаар замын дагуу харагдах шугам тодорхой болж тээврийн хэрэгслүүд Оюу Толгой-Гашуун Сухайтын замыг хурдан бөгөөд шулуун нэвтэрч өнгөрөх бололцоотой болох юм. Замын аюулгүй байдлын талаар хийх ажлуудыг *Бүлэг D11: Тээврийн менежментийн төлөвлөгөөнд* дэлгэрэнгүй тодорхойлсон. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд хийгдэх гол ажлуудад доорхи арга хэмжээнүүд багтана:

- Замын нөхцөл ба зам зуур тохиолдох эрсдэлтэй суурин газруудын байршлаас шалтгаалж хамааруулан хурдны дээд хязгаарыг тогтооно;
- Оюу Толгойн бүх тээврийн хэрэгслүүд, гэрээт гүйцэтгэгч компаний тээврийн хэрэгслүүдэд суурин газруудаар болон хурдны хязгаарын тэмдэг тавиагүй газруудаар дайрч өнгөрөх хурдны хязгаарыг тогтоож өгнө. Оюу Толгой төсөл нь орон нутгийн цагдаагийн байгууллага, хот/тосгоны удирдлагуудтай зөвшилцсөний үндсэн дээр хурдны хязгаарыг тогтооно.

Оюу Толгой нь хүмүүс болон мал амьтанд учирч буй замын ослыг бууруулах үүднээс замын тэмдэг тавих, хурдны хязгаарыг тогтоох зэрэг хөдөлгөөний аюулгүй байдлын тодорхой санаачлагуудыг хэрэгжүүлнэ.

Дээр дурдсан арга хэмжээнүүдээс гадна, Оюу Толгой нь төслийн ашиглалтын үе шатанд Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын Хөтөлбөрөө үргэлжлүүлнэ. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын Хөтөлбөрийн <sup>8</sup> 2-р шатанд орон нутгийн иргэдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, холбогдох арга хэмжээг авах зэрэг үйл ажиллагаа багтана. Үүнд:

<sup>6</sup> Оюу Толгой төслийн Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ Хөх Тэнгэр Хөгжил Консорциум, 2011, (хээрийн судалгааг 2010 онд явуулсан).

<sup>7</sup> 2010 оны 7 ба 8 сард малчидтай өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлж мал амьтан гарах гарцны байршил болон тэмдэгжүүлэлтийн байршлыг тодорхойлсон. Оюу Толгой-Гашуун Сухайт чиглэлийн зам дагуу ойролцоо нутагладаг 12 айл өрх болон Жавхлант багийн засаг даргатай төслийн Олон нийттэй харьцах хэлтсийн ажилтнууд ажилласан. Нийт 11 мал амьтан гарах гарцыг тодорхойлсон бөгөөд эдгээрийг газрын зурагт тэмдэглэн замын зураг төсөлд тусгасан.

<sup>8</sup> Энэ бүлэгт өгүүлсэнчлэн Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын хөтөлбөрийн 1 шатанд үнэлгээг хийлгэсэн.

- Дэлхийн Замын Аюулгүй Байдлын Түншлэл зэрэг туршлагажсан төрийн бус байгууллага (ТББ)-тай олон нийтийг аюулгүй байдлын талаар тодорхой мэдлэгтэй болгох компани ажилд хамтран ажиллах. Үүнд, наад зах нь Ханбогд, Манлай сумуудын малчид, оршин суугчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар танилцуулга өгөх;
- Оюу Толгойгоос замын аюулгүй байдал хангах болон яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг нь нэмэгдүүлэх арга хэмжээ авна. Үүнд: түргэн тусламжийн тэрэг, гэмтлийн төв/эмнэлгийн үйлчилгээний тоног төхөөрөмж гэх мэт;
- Орон нутгийн иргэдэд эмнэлэгийн анхны тусламж болон аюулгүй ажиллагааны сургалт явуулах;
- Оюу Толгойгоос Төслийн замын хөдөлгөөний ойр орчим байрлах оршин суугчдад зориулан Олон нийтийн Онцгой Байдлын үед авах Арга хэмжээний Төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Үүнд зам тээврийн осол болон химийн бодис, бусад аюултай материал алдагдахтай холбоотойгоор үзүүлэх түргэн тусламж, хариу арга хэмжээний талаар оруулна.

### Нөлөөллийн зэрэглэл

Замын тоо болон хөдөлгөөн нэмэгдсэнээс **орон нутгийн шинжтэй** иргэдийн аюулгүй байдлын эсрэг аваар осол **урт хугацаанд** тохиолдох **магадлалтай** болоод байна. Малчид, хүүхдүүд, бусад эрсдэлд өртөмтгий хүмүүс, мал сүрэг зэрэг нь зам хөндлөн гарах туршлагагүй байж болно. Дээр дурьдсан замын аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, олон нийттэй байнгын харьцах ажлыг хэрэгжүүлсэн тохиолдолд үлдэгдэл нөлөөллийн зэрэглэлийг нь **дундаж сөрөг түвшинд** байна гэж үзэж байна. Урт хугацаанд нутгийн иргэд суман дотроо замын хөдөлгөөнд илүүтэй оролцож, замын аюулгүй байдлын асуудлуудын талаар илүү ойлголт мэдлэгтэй болох үед энэхүү нөлөөлөл нь **бага сөрөг түвшинд** хүртэл буурах буюу үүнээс ч илүү буурах боломжтой юм.

### 12.3.3 Төслөөс Үүдэлтэй Аюул Эрсдэлд Олон Нийт Өртөх

#### Нөлөөллийн тодорхойлолт

Уурхайн талбай болон холбогдох байгууламжууд нь Ханбогд сумын хүн ам сийрэг суурьшсан бүсэд байршдаг. Гэвч төслийн орчмын нутаг нь хөдөөгийн малчдын малаа бэлчээрлүүлдэг уламжлалт газар нутаг юм. Барилга байгууламжийн томоохон ажлууд мөн том хэмжээний уурхай нь Ханбогд сумын хувьд шинэ зүйл бөгөөд хөдөө нутгийн хүмүүст аюулгүй байдлын болзошгүй аюулыг бий болгож байна. Барилгын үйл явцтай холбоотой үүсэх тодорхой эрсдлүүдэд доорхи зүйлс багтана:

- Нисэх онгоцны буудлаас үүсэх аваар осол, гал түймэр, их дуу чимээ
- Барилгын үйл ажиллагаа болон ил уурхайн олборлолтын ажилтай холбоотой тэсэлгээ;
- Аюултай бодис, хог хаягдлын нөлөөнд өртөх;
- Үйлдвэр/уурхайгаас ялгаран гарч байгаа тоосжилт, хорт хийн ялгаруулалт;
- Хүнд механизм, барилгын ажилтай холбоотойгоор үүсэх аюулгүй байдлын асуудлууд;
- Түлш шатахуун, цахилгаан, ил задгай тавьсан галын улмаас нутгийн иргэдэд гал түймрийн аюул учрах.

Төслийн байгууламжуудын ойролцоо оршин суудаг буюу малаа бэлчээдэг малчин өрхүүд нь хамгийн их эрсдэлд орох магадлалтай, учир нь өдөр тутам малаа бэлчээдэг нь хүмүүс болон хүнд машин, тоног төхөөрөмжтэй ойртож харьцахад хүргэж байгаа юм. Үр дүнтэй хамгаалалт болон аюулгүй байдлын арга хэмжээ авахгүй тохиолдолд малчид гэмтэж бэртэх болон/буюу малын хорогдол гарч болзошгүй байна. Жишээлбэл, мал амьтан онгорхой гуу жалга руу буюу өөр ижил төстэй зүйл рүү унаж болно, иймэрхүү явдал Оюу Толгойн зарим барилга байгууламжийн талбайд тохиолдож байсан. Барилгын ажлын үеэр ашиглах жижиг усан сан нь мөн насанд хүрэгчид, хүүхдүүд, мал амьтдад аюул учруулж болно.

Төслийн барилга байгууламжийн үйл ажиллагаа нь нутгийн иргэдэд маш бага эрсдэлтэй хэмээн үзэж байна. Учир нь аюултай үйл ажиллагааны талбайг хашиж нутгийн иргэдийг нэвтрэх боломжоор хязгаарлана. Гэвч малчид уг барьсан хашаа хаалт малд аюул учруулж боломжтой үзэж байгаа бөгөөд УЛТ болон нисэх онгоцны буудлын хашаанд мал орооцолдож байсан талаар тайлан байна.

Малчдыг Нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон төслийн талбайн хашаа хаалтыг барьснаар малчид гал түймэр, дэлбэрэлт, бусад аюулд өртөх аюулд өртөх эрсдэл багасна. Жишээлбэл, эргэн тойрон 10 км-ийн хориотой бүсэд орон нутгийн малчид байхгүй. Үүнтэй адилаар менежментийн зохих арга хэмжээг хэрэгжүүлж, малчдыг ашиглалтын талбайгаас холдуулснаар тоос шороо болон химийн нөлөөлөлд өртөх эрсдэл багассан. Оюу Толгой-Гашуун Сухайтын замыг сайжруулах ажил бүрэн дуусах хүртэл энэ зам дагуу тоосжилтоос үүдэх эрсдэл хэвээр байгаа бөгөөд үүнийг цаашид Хэсэг 12.3.7-д авч үзнэ.

Төслийн татан буулгах болон хаалтын шатанд олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой асуудал үүсгэж болзошгүй гол үйл ажиллагаануудад боловсруулах үйлдвэрийг татан буулгах, тоног төхөөрөмжийг авах болон хаалтын дараа байран дээрээ үлдэх ил уурхай ам, хаягдал чулуулгийн овоолго ба далд уурхайтай холбоотойгоор суулт өгсөн газар зэрэг юм.

#### **Нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Барилгын ажлын болон ашиглалтын үед олон нийтийн аюулгүй байдлын эрсдлийг бууруулах хяналтын арга хэмжээнүүд нь бодит/инженерингийн хяналт, аюулгүй ажиллагааны горим, орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зэргийг хослуулан хэрэгжүүлэх явдал болно.

Гэнэтийн осол, *онцгой байдлын хяналтыг Онцгой байдлын үед авах Хариу арга хэмжээний төлөвлөгөө бүлэгт тодорхой тусгасан.*

Хаалтын үе шатанд бүх машин, механизм, тоног төхөөрөмж болон аюултай байж болох бодис, материалуудыг талбайгаас холдуулж, ил уурхайнуудыг аюулгүй болгож, бусад аюултай байж болох газруудыг хүн буюу мал хүрч очиж чадахааргүйгээр хамгаална. Аюулгүй байдалд учрах эрсдэл гэх зэрэг ЭМААА-ны үзүүлэх нөлөөлөл нь хаалтын үе шатанд хамгийн бага байна гэж үзэж байна.

#### **Нөлөөллийн зэрэглэл**

Хэдийгээр ард иргэдийн аюулгүй байдалд үзүүлж болзошгүй нөлөөлөл маш чухал боловч, бүх ажлын талбай болон УЛТ-н эргэн тойронд тогтоосон хориотой бүсэд зохих хяналтыг хэрэгжүүлэх тохиолдолд орон нутгийн хүмүүст ноцтой бэртэл гэмтэл, эндэгдэл тохиолдох **магадлалгүй** байна. Хувь хүн болон орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл нь байнгын (**урт хугацааных**) боловч **зөвхөн орон нутгийн шинжтэй**. Иймд төслийн үйл ажиллагаанаас аюулд өртөх явдлыг **дундаж сөрөг** гэж тодорхойлж болно. Цаг хугацаа өнгөрөхөд иргэд орон нутаг дахь ашиглалтын үйл ажиллагаанд зохицож, холбогдох аюулгүй байдлын журмыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлдэг болох тул энэхүү нөлөөллүүд нь **бага сөрөг түвшинд** хүртэл буурах буюу түүнээс илүү буурах юм.

### **12.3.4 Халдварт Өвчний Нэмэгдсэн тохиолдлууд**

#### **Нөлөөллийн тодорхойлолт**

Монгол улсад хэмжээнд анхаарах шаардлагатай халдварт өвчнүүдэд (*Бүлэг В13*: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд дурдсанаар) сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ), бруцеллөз зэрэг өвчнүүд орно. Өмнөговь аймагт, 10,000 хүн тутамд бүртгэгдсэн халдварт өвчний тоо 2005 онд 41.3 байсан бол, 2009 онд 58.8 болж нэмэгдсэн байна. Ханбогд суманд энэ хэмжээ 2005 онд 10,000 хүн тутамд 11 тохиолдол байсан бол, 2006 онд 21, 2007 онд дахин 11, 2008 онд 20, 2009 онд 22 болсон байна.

2011 оны 12-р сарын байдлаар Оюу Толгой төслийн барилгын үе дэхь ажилчдын тоо нь 14,800 болж (Оюу Толгойн бүх ажилчид болон гэрээт гүйцэтгэгч нарыг оруулаад) хамгийн дээд цэгтээ хүрсэн бөгөөд энэ нь тухайн үедээ Монгол улс дахь хамгийн том ажил олгогч болгосон юм. Үүний 10,000 буюу нийт ажиллах хүчний 67% нь Монгол улсын иргэд байсан байна<sup>9</sup>. Ашиглалтын үед ажиллах хүч 3,000-4,000 орчим хүн байх бөгөөд эдгээрийн 75 гаруй хувь нь Монголчууд байна. Төслийн хэрэгжилтийн үр дүнд шилжин ирэх ажилчид болон бусад шилжин ирэгсдийн урсгал

<sup>9</sup> Оюу Толгойн Ажиллах хүчний мэдээллийн сан, 2011 оны 12 сарын 19

Ханбогд сумын хүн амыг өөсгөж 2010 онд 3,500 хүн амтай байсныг 2020 оны үед 20,000 хүртэл өсгөх төлөвтэй байна (мөн Бүлэг С8: Хүн ам ба шилжилт хөдөлгөөнийг үзнэ үү)<sup>10</sup>.

Ийнхүү хэдэн мянган ажилчид болон бусад шилжин ирэгсэд төслийн бүсэд ирэх нь БЗХӨ болон бусад халдварт өвчнүүд тархах эрсдлийг нэмэгдүүлэхээр байна. Бэлгийн замын халдварт өвчин бол Монгол улсад хамгийн гол зонхилж байгаа (40%) халдварт өвчин юм. Хэдийгээр Өмнөговь аймагт ХДХВ/ДОХ-ын тохиолдол бүртгэгдээгүй ч, Монгол улсад бүртгэгдсэн тохиолдлын тоо хурдацтай өсч байгаа бөгөөд энэ бүс нутагт сорил шинжилгээний арга хэмжээг явуулах боломжтой боловч өргөн дэлгэр хэрэгждэггүй байна<sup>11</sup>. Хэрэв энэ бүс нутагт ХДХВ/ДОХ-ын тохиолдол ихэсвэл, сүрьеэгийн эрсдэл нэмэгдэх магадлал өндөр байна учир нь ХДХВ/ДОХ болон сүрьеэ нь хам шинж хэлбэрээр тархдаг. Бүлэг В13: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал-д дурьдсанаар тус аймагт тэмбүү, заг хүйтэн, шигелла өвчний бүртгэгдсэн тохиолдол бүгд сүүлийн таван жилийн хугацаанд нэмэгдсэн байна. Хүн амын шилжилт хөдөлгөөнөөс өмнө санхүүжилтийн дутагдалтай, хүн амд зохих үйлчилгээг үзүүлэх боломжгүй байсан орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоо хүн амын шилжилт хөдөлгөөний үр дүнтэй холбоотой ихээхэн ачаалалтай тулгарах болно<sup>12</sup>.

Уул уурхай болон тээврийн салбарт ажиллаж буй уурхайчид, ачааны машины жолооч нар, мөн даган ирж байгаа биеэ үнэлэгчдийг БЗХӨ-ийг дамжуулах өндөр эрсдэлтэй бүлгийнхэн гэж үзэж байна. Таван Толгой, Оюу Толгой, Хятадын хилийг холбох ирээдүйн сайжруулсан тээврийн зам нь албан бус бизнес эрхлэгчид, биеэ үнэлэгчдийг татах төв болох бөгөөд ингэснээр тухайн бүс нутагт БЗХӨ, ХДХВ/ДОХ дамжих болзошгүй зам /суваг/ болохоор байна<sup>13</sup>. Мөн Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх үнэлгээний хэлэлцүүлгийн үеэр биеэ үнэлэх явдал өсч, үүнийг дагаад БЗХӨ-ний түвшин ихээхэн нэмэгдэж байгааг орон нутгийн иргэд хэлж байсан. 2009 онд Ханбогд суманд бэлгийн замын халдварт өвчний гурван тохиолдол бүртгэгдэж байсан бол, 2010 онд дахин гурван тохиолдол бүртгэгдсэн байна<sup>14</sup>. Ярилцлага өгч судалгаанд оролцогчид болон судалгааны бүлгийнхэн энэхүү өсөлтийг гэр орноосоо хол ажиллаж, кэмпэд амьдарч байгаа ажилчдын “гэр бүлийн бус амьдралын орчин”-д хамаатуулан тодорхойлсон байна<sup>15</sup>. Хэдийгээр бүртгэгдсэн тохиолдлын тоо (өнөөдрийг хүртэл) маш цөөн байгаа боловч энэ нь дээр дурьдсанчлан шинжилгээ хийх боломж байхгүй эсвэл хүн амын тоо цөөн зэргээс тодорхой хэмжээгээр хамаарч байж болох юм.

Нэг дор бөөнөөр амьдарч байгаа явдал, олон тооны ажилчид, шилжин ирэгсэд ариун цэврийн болон бусад байгууламжуудыг хамтран хэрэглэж байгаа байдал, мөн эрүүл ахуйн нөхцөл муу байх зэрэг нь амьсгалын замын өвчин, цаашлаад хоол хүнс, уснаас үүдэлтэй өвчнүүдийн (жишээлбэл, холер өвчин, гэдэсний хижиг) эрсдлийг нэмэгдүүлж болох юм. Хэрэв Ханбогд, Даланзадгад сумдуудад төлөвлөгдөөгүй хүн ам суурьших боломж олговол энэ нь орон нутгийн хүн амын дунд эдгээр өвчнүүд нэмэгдэх эрсдлийг ихээхэн нэмэгдүүлэх юм.

### **Нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Оюу Толгой нь тус сум болон аймагт халдварт өвчин ихсэх эрсдлийн талаар мэдэж байгаа бөгөөд эдгээр эрсдлүүдийг тодорхой механизмуудаар дамжуулан арга хэмжээ авах болно. Олон нийтийн дунд халдварт өвчний тархалтыг бууруулах хамгийн чухал тал нь ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах явдал, ялангуяа олон ажилчид орон нутгийн иргэд байдаг тул чухал юм.

<sup>10</sup> Азийн Хөгжлийн Банкны 2009 оны тооцоон дээр үндэслэж Оюу Толгой компани Ханбогд суманд зориулж 2010 онд өөрчилсөн. Үүнийг Цогтцэций суманд шилжин ирэгсдийн төлөв байдал дээр үндэслэн мэдээг шинэчилсэн.

<sup>11</sup> Оюу Толгой төслийн Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум 2011

<sup>12</sup> *Ibid*, Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум 2011.

<sup>13</sup> Оюу Толгой төслийн Хүн амын шилжилт хөдөлгөөний эрсдлийн үнэлгээ, Barclay & Associates, 2007 оны 10 сар.

<sup>14</sup> Аймгийн эрүүл мэндийн хэлтэс 2011, Эрүүл мэндийн үзүүлэлтүүд

<sup>15</sup> *Ibid*, Оюу Толгой төслийн Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум 2011



Оюу Толгой нь ажилд ирэхэд болон гарахад бүртгүүлэх бодлого болон сумын төв рүү зорчих зааварчилгаа зэргийг оруулсан Оюу Толгой Төслийн Кемпийн Бодлого болон Ёс зүйн дүрмээр (2009) дамжуулан ажиллах бүрэлдэхүүнээ хянах хатуу арга хэмжээг хэрэгжүүлж байна. Ёс зүйн дүрмийг тогтмол давтан сургалт, хариуцсан ахлагч нарын хяналт, зөрчсөн тохиолдолд тогтоосон сахилга батын арга хэмжээг авах, мөн Төслийн Гомдол саналын журмын дагуу авсан мэдээллийг шалгах замаар хангадаг. Кемпийн Бодлого, Ёс зүйн дүрэм-г *Бүлэг D17: Хөдөлмөр эрхлэлтийн Менежментийн Төлөвлөгөө*-ний “Б” хэсрэлтээс үзнэ үү.

### **Нөлөөллийн зэрэглэл**

Халдварт өвчнүүд тодорхой хэмжээгээр нэмэгдэх **магадлалтай, урт хугацаанд** үргэлжлэхээр байгаа боловч **орон нутгийн шинжтэй**. Орон нутгийн иргэд өвчлөх нь ноцтой байх тул, халдварт өвчний үзүүлэх нөлөөллийг **дундаж сөрөг** гэсэн түвшинд хамааруулна. Харин урт удаан хугацаанд иргэд орон нутгийн иргэд эрүүл мэндийн үйлчилгээний боломж сайжирсны ашиг тусыг хүртэж халдварт болон бэлгийн замаар дамжих өвчнүүдийн талаарх мэдлэг нь дээшлэх тул энэхүү нөлөөлөл нь **бага сөрөг түвшинд** хүртэл буурах буюу түүнээс илүү буурах боломжтой юм.

### **12.3.5 Хамгаалалтын Албаны үйл ажиллагааг эхлүүлэх**

#### **Нөлөөллийн тодорхойлолт**

Барилгын ажил явагдаж байгаа газар, уурхайн талбайг хянаж, зохицуулах хамгаалалтын албан хаагчид нь ажиллагсад, олон нийт болон төслийн машин, тоног төхөөрөмж, хангамжийн зүйлийн аюулгүй, найдвартай байдлыг хангахад гол үүрэгтэй юм. Одоогийн байдлаар Оюу Толгойн талбай дахь хамгаалалтын үйлчилгээг Монголын харуул хамгаалалтын компани туслан гүйцэтгэж байдлаар гүйцэтгэж байна. Хамгаалагч нарыг УБ хотоос сонгон шалгаруулж ажилд авч байна. . Хамгаалагч нар уурхайн талбай болон үндсэн уурхайн талбайгаас хойд болон өмнө хэсэгт байрлах бусад кемпүүдэд хамгаалалтын үйлчилгээ үзүүлдэг. Хамгаалалтын хоёрдахь компани нь гадны мэргэжилтний аюулгүй байдлыг хангах чиглэлээр, ялангуяа Улаанбаатар хотын үйл ажиллагаанд гэрээт хамгаалалтын үйлчилгээ, зөвлөгөө өгч ажилладаг. . Уг хоёр компани нь Засгийн газрын гэрчилгээ зөвшөөрөлтэй юм. Тэсэрч дэлбэрэх бодис хянах хамгаалалтын албаны хүмүүсээс бусад нь зэвсэглээгүй байдаг.

Орон нутагт хамгаалалтын ажилтнуудыг ажиллуулах нь нутгийн оршин суугчид болон хамгаалалтын албаныханы хооронд зөрчилдөөн үүсгэж болох юм. Оюу Толгой нь барилгын ажил явагдаж байгаа эсвэл бусад аюул эрсдэлтэй талбай болон/эсвэл Хориотой бүсийн доторхи талбайгаас бусад түр ажлын талбайд малчид, мал амьтдыг орохыг хориглохгүй байх бодлого баримтална. УЛТ-н эргэн тойронд байнгын хашаа хаалтыг барьсан бөгөөд бүх газруудад хамгаалалтын ажилтнууд байрлах болно. Орон нутгийн зарим малчид, бусад иргэд хориглогдсон бүсүүдэд нэвтрэх боломжгүй байгаад бухимдаж байгаагаа илэрхийлсэн. Тухайлбал, нутгийн зарим малчид бэлчээр ашиглах боломжгүй болсны төлөө нөхөн олговор авсан боловч, хамгаалалтын ажилтнууд хамгаалалтын хашааны ойролцоо мал бэлчээхгүй байх, барилгын үйл ажиллагаа явагдаж байгаа газрын орчим явуулахгүй байх зэрэгт дурамжхан байгаагаа илэрхийлсэн байна.

Хэрэв төслийн хамгаалалтад хүч хэтрүүлэн хэрэглэх, ялангуяа төслийн талбайн хил хязгаар, дэд бүтцэд хамаарах дүрэм журам тодорхойгүй буюу (жишээлбэл, төслийн хашааг давж гарах) дүрэм журмыг хүндэтгэж үзэхгүй тохиолдолд нутгийн иргэдийн аюулгүй байдалд мөн бусад эрсдэл учирч болох юм. Хамгаалалтын албыг ажиллуулах нь зарим үед төслийн хамгаалалтын шаардлагыг хэрэгжүүлэх нэрийн дор орон нутгийн иргэдтэй буруу харьцахад хүргэж болзошгүй.

#### **Нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Оюу Толгой нь ОУСК-ын Гүйцэтгэлийн 4-р стандарт болох Хамгаалалт болон Хүний эрхийн сайн дурын зарчмууд <sup>16</sup> ЕСБХБ-ны Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд

тавигдах Гүйцэтгэлийн 4-р шаардлага гэх зэрэг олон улсын практикийн дагуу хүмүүс болон өмч хөрөнгийг хамгаалах явдлыг хангахад бэлэн байна. Үүнд хүрэх тодорхой арга хэмжээнүүдэд :

- Төсөлд үйлчилгээ үзүүлж байгаа хамгаалалтын компани нь Монгол компани юм. Бүх хамгаалалтын ажилтан нар Монгол улсын иргэд бөгөөд зэвсэгт хүчинд хамааралгүй,

<sup>16</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг [www.voluntaryprinciples.org-c](http://www.voluntaryprinciples.org-c) авна уу

тэсрэх бодисын агуулахын харуулаас бусад нь зэвсэглээгүй байна. Оюу Толгой болон хамгаалалтын албаны хоорондох гэрээ ёсоор хамгаалалтын албаны ажилтан нар сайн бэлтгэгдсэн, гэмт хэрэгт холбогдоогүй байдаг;

- Оюу Толгой болон түүний гэрээт гүйцэтгэгчид төсөлд ямар нэгэн хамгаалалтын албаны үйлчилгээ авахын өмнө аюулгүй байдалд үнэлгээ хийдэг. Оюу Толгой нь хамгаалалтын алба гэрээнд заасан болон бусад шаардлагуудын дагуу ажиллаж байгаа эсэхийг тогтоох үүднээс хамгаалалтын гэрээт гүйцэтгэгчид хөндлөнгийн хяналт шалгалт явуулна;
- Оюу Толгой нь *Хүний эрхийн түгээмэл тунхаглал* дээр үндэслэн өөрийн ажиллагсад, гэрээ гүйцэтгэгчид болон гэрээт хамгаалалтын албаныханд Хүний эрхийн талаарх сургалтыг явуулна. Оюу Толгойн Олон нийттэй харилцах болон Нийгмийн асуудал хариуцсан хэлтэс нь Монголын улсын Хүний Эрхийн Үндэсний Комисстой <sup>17</sup> хамтран өөрийн ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч компаниуддаа зориулан хүний эрхийн талаарх сургалтыг санаачлан явуулсан;
- Оюу Толгой нь төслийн талбайгаас гадна болсон аливаа хэрэг зөрчилд аваар ослын үед авах арга хэмжээний дүрэм журмын хэрэгжилтийг баталгаажуулах үүднээс (*Бүлэг D20: Онцгой байдлын үеийн бэлэн байдал болон Хариу арга хэмжээний төлөвлөгөө*-г үзнэ үү) хөндлөнгийн оролцогч талуудыг (тухайлбал, цагдаа, сум/аймгийн удирдлагууд) оролцуулдаг. .

Эдгээр арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүйг *Бүлэг D18: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө*-нд үзүүлэв. Барилгыг болон ашиглалтын явцад хамгаалалтын албаныхантай холбоотой ямар нэгэн асуудал гарч байгаа эсэхийг хянах зорилгоор орон нутгийн иргэдийн Санал гомдлыг барагдуулах механизмыг хэрэгжүүлж байна. Энэхүү механизмаар ирсэн гомдол саналыг ангилан ялгаж хамгаалалтын ажиллагаатай холбоотой гомдлыг мөн тэмдэглэнэ. *Бүлэг D14 Оролцогч ба сонирхогч талуудын оролцооны төлөвлөгөө*-нд энэхүү журмын хувийг оруулсан бөгөөд бусад төрлийн гомдлуудыг мөн бүртгэсэн байдаг. Энэхүү журмыг орон нутгийн иргэдийн хувьд мөн хэрэгжүүлж байна. Орон нутгийн иргэдийн баг төслийн хамгаалалтын алба болон орон нутгийн олон нийттэй холбоотой аливаа асуудалд оролцож болно.

### **Нөлөөллийн зэрэглэл**

Хамгаалалтын ажилтанууд талбайн тойргийн гадуур байгаа малыг хөөсөн, орон нутгийн хүмүүсийг барилгын талбайд орохыг хориглосон гэх зэрэг цөөн гомдлууд гарсан байгаа. Иймд нөлөөлөл нь **зайлшгүй, урт хугацааных гэвч зөвхөн орон нутгийн шинжтэй** байна. Хамгаалалтын бие бүрэлдэхүүнд зохих үнэлгээ, хяналт, мониторинг болон зохицуулалтуудыг хэрэгжүүлсэнээр энэхүү нөлөөлөл нь **бага сөрөг түвшинд** байхаар байна. Харин урт хугацаанд төслийн үйл ажиллагаанд дасч уурхайн үйл ажиллагаа ашиглалтын тогтвортой түвшинд очиж хамгаалалтын албаны шаардлага сулрах үед нөлөөлөл нь маш бага түвшинд буурах юм

### **12.3.6 Хувь Хүний Эрүүл Мэнд, Аюулгүй Ажиллагаа Доройтох**

#### **Нөлөөллийн тодорхойлолт**

Орон нутгийн хүн амын бүтцэд ажилчдын болон бусад хүмүүсийн шилжилт хөдөлгөөн ихсэх, мөн уламжлалт газар нутагт тулгуурласан амьдралын хэв маягт өөрчлөлт орсноор хувь хүний аюулгүй ажиллагаа болон эрүүл мэндэд дараах нөлөөлөл гарч болно:

- Гэмт хэрэг ихсэх;
- Архи согтууруулах ундаатай холбоотой өвчлөл, осол гэмтэл ихсэх;
- Цагдаагийн алба, төрийн үйлчилгээнд ачаалал нэмэгдэх;
- Малчдын эрүүл мэнд доройтох;
- Хүний наймаа зэрэг юм.

<sup>17</sup> Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол улсад хүний эрхийн соёлыг түгээх зорилготой төрийн байгууллага юм.

Хэлэлцүүлгийн явцад орон нутгийн иргэд хувийн аюулгүй байдал санаа зовоох асуудал болохыг илэрхийлж байсан бөгөөд үүнд орон нутагт шинээр ирсэн ажилчид болон бусад хүмүүс хувь хүний аюулгүй байдал, өмч хөрөнгөнд зүй бус, сүйтгэлтэй хандах эрсдэл багтана<sup>18</sup>. Урьд нь Ханбогд болон ойролцоох сумдад гэмт хэрэг маш бага гардаг байсан. Тус суманд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 2009 онд 41, 2010 онд 38 байсан, гэвч нөхцөл байдал өөрчлөгдөж байна хэмээх ойлголт байна<sup>19</sup>. Малчдад ялангуяа хулгайн болон бусад өмч хөрөнгө, хувийн эрх чөлөөнд халдах гэмт хэрэгт өртөх магадлалтай байна гэж үзэж байна. Өмнө нь хулгайн хэрэг нь хэзээ ч асуудал үүсгэж байгаагүй, малчид гэр орон, эд зүйлээ бараг цоожилдоггүй байсан. Одоо *гадныхан ирэх нь ихэссэн бөгөөд* жишээ нь, мотоцикль унасан залуучууд хот айл, гэр рүү очих нь их болсон<sup>20</sup>. Гэмт хэрэг ихэссэнээс үүсэх нөлөөнд өмч хөрөнгөө, амьжиргаагаа алдах, (биеийн/бэлгийн) хүчирхийлэл, хувь хүний эрх чөлөөнд халдах зэрэг хамаарч байгаа юм. Ажилчид болон гэрээт гүйцэтгэгч компаниудын ажиллагсад архи, согтууруулах ундаа хэрэглэсэний улмаас хулгай гэх зэрэг жижиг гэмт хэрэг үйлдэхэд бэлэн байх болно гэж орон нутгийн иргэд үзэж байна.

Амьдралын хэв маяг өөрчлөгдсөний улмаас үүдэх өвчлөл, гэмтэл бэртэл нь (гэмтэл, хүчирхийлэлтэй холбоотой, зам тээврийн осол, архитай холбоотой өвчлөл) Монгол улсад сүүлийн таван жилд мэдэгдэхүйцээр өсч байгаа нь харагдаж байна<sup>21</sup>. Зөвхөн Өмнөговь аймагт 2007 онд 3,076 хүн эрүүлжүүлэх төвд эмчлэгдсэн байна. Энэ нь өмнөх жилтэй харьцуулбал 2007 онд 16%-иар нэмэгдсэн байна. Архидалт нь аймаг даяар (Монгол орны бусад аймаг сумдад ч адил) нийгмийн асуудал болсон бөгөөд Лхагва гараг бүрийг “Архигүй” өдөр болгож, бүх газарт архи худалдаалах, худалдан авахад хориг тавьдаг. Мөн Төслийн Нөлөөллийн Бүс дэх сумдын эрүүл мэндийн салбарынхан архины гүн хордлого болон архитай холбоотой бэртэл гэмтэл гарч байгаа талаар ЭМАААБ-д нөлөөлөх байдлын үнэлгээний судалгааны багт мэдэгдсэн байна<sup>22</sup>. Гэмт хэрэг ихэссэн, нийгмийн хэв журмын эсрэг үйлдлүүд нь Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо сумдын хүн хүч бололцоо муу байгаа цагдаагийн албанд ачаалал үүсгэнэ.

Үүний зэрэгцээ гадныхан ихээр орж ирэх болсон, тээврийн хэрэгслийн их хөл хөдөлгөөн, Хятадын хилийг ирээдүйд урт хугацаагаар нээх төлөв байдал зэргийн улмаас Оюу Толгой болон тус бүс нутаг дахь бусад уул уурхайн үйл ажиллагаа нь хүн хил давуулан худалдаалах гэмт хэрэг ихсэхэд нөлөөлөх эрсдэл байна. Оюу Толгойн ЭМАААБ-д нөлөөлөх байдлын үнэлгээ нь 2010 онд хийгдсэн бөгөөд хүнийг хил давуулан худалдаалах эрсдлийн магадлал одоогоор бага байгаа боловч орон нутгийн хүн амын тоо ихсэж, тус бүсэд (Оюу Толгой болон бусад төслүүдтэй хамаарах) уул уурхайн үйл ажиллагаа нэмэгдсэний улмаас шинэ асуудлууд үүсч болно гэж дүгнэсэн байна.

Мөн орон нутгаас төсөлд ажиллаж буй иргэд ажлын цаг хуваарьтай холбоотойгоор аюулгүй байдал болон эрүүл мэндэд бэрхшээл учрах, мөн ажилчдын хооронд зөрчил үүсэх зэрэг асуудал гарч болно. Ерөнхийдөө ажил хийдэг эцэг эхийн (голдуу эрэгтэй) нэг нь 3 долоо хоногоор (3 долоо хоног ажиллаж, 1 долоо хоног амардаг) явж ажилладаг бөгөөд нөгөө нь өдрийн ажилтай байдаг тул эцэг эх хоёулаа байхгүй байхад хүрдэг. Сургуулийн өмнөх болон сургуулийн насны олон хүүхдүүд эцэг эх нь ажилтай байдгийн улмаас харж хандах хүнгүй, эсвэл ийм боломжоор хязгаарлагдмал байдаг. Зохих нөхцөл хангасан хүүхэд асрах төвүүд байхгүй бөгөөд хүүхдийн цэцэрлэгүүдийн ачаалал ихэссэн байна (*Бүлэг В13: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал-г үз*). Гэр бүл тусдаа амьдрах, мөнгө хүрэлцэхгүй байх, архи ихээр хэрэглэх зэрэг нь стресс үүсгэх, гэр бүл салахад хүргэж байна гэж мэдээлсэн байна.<sup>23</sup>

<sup>18</sup> Оюу Толгой төслийн Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ, Эцсийн тайлан, 2009 оны 9 сар. МУИС, Эдийн засгийн ухааны сургууль, Бодлого судлалын Төв, Хүн амын Сургалт, Судалгааны төв. Хуудас 67

<sup>19</sup> Ханбогд сумын засаг даргын тамгын газраас Оюу Толгой төсөлд 2011 онд өгсөн мэдээлэл, Бүлэг В15: *Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал (суурь нөхцөл байдал)*.

<sup>20</sup> Оюу Толгой төслийн *Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ*, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум 2011 (хээрийн судалгааг 2010 онд хийсэн).


<sup>21</sup> Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Монгол улстай хамтран ажиллах түншлэлийн стратеги, Монгол 2006, *Бүлэг В15: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал (суурь нөхцөл байдал)*.

<sup>22</sup> Оюу Толгой төслийн *Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ*, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум 2011 (хээрийн судалгааг 2010 онд хийсэн).

<sup>23</sup> *Ibid*, Оюу Толгой төслийн *Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөх байдлын үнэлгээ*, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум 2011.

2010 оны туршид барилгын ажилчидтай холбоотой хэд хэдэн хамгаалалтын асуудал үүссэн байна, ялангуяа СИАЙЭС кэмп<sup>24</sup> дээр асуудлууд үүссэн. СИАЙЭС кэмп нь Ханбогд сумын төвийн хажууд байрладаг ба Оюу Толгойн удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг барилгын ажилчидын кэмп юм. Оюу Толгой төслийн үйл ажиллагаатай холбоотой кэмпүүдийн байршилыг Зураг 12-1-д үзүүлэв.

**Зураг 12-1 Барилгын ажилчдын кэмгийн байршил**



Үүнд янз бүрийн үндэстэн барилгын ажилчид хоорондын зөрчилдөөн, нэг үндэстнүүдийн хоорондын маргаан, мөн нутгийн Монгол эмэгтэй ажилчдыг дарамталсан тохиолдол гарсан байна.

Рио Тинтогийн Олон улсын Аюулгүй байдал ба олон нийтийн байгууллага нь Оюу Толгой төсөлд 2010 оны 11 сард Ажиллах хүчний зөрчлийн үнэлгээг<sup>25</sup> хийсэн бөгөөд үүнд зөрчилдөөний улмаас төсөл болон нутгийн иргэдэд учирч болзошгүй нөлөөллийг үнэлсэн. Үнэлгээний багийнхан төсөл доторхи болон гадны олон оролцогч талуудтай өргөн хэмжээний ярилцлага судалгааг хийж болзошгүй эрсдэл болон маргаан зөрчилдөөнийг тодорхойлсон. Эдгээр зөрчилдөөнийг үүсч хүч хэрэглэх байдалд хүрэхээс сэргийлэхийн тулд үнэлгээний баг хэд хэдэн зөвлөмжүүдийг гаргасан. Ажиллах хүчний эдгээр асуудлууд нь Оюу Толгой төслийн хувьд чухал юм. Ажиллах хүчний зөрчлийн үнэлгээний дараагаар Оюу Толгой нь *Төслийн талбайн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө: Ажиллагсдын хүчирхийлэл*-г 2011 оны 1 сард эцэслэн боловсруулсан<sup>26</sup>. Энэ төлөвлөгөөний зорилго бол хүн амыг хамгаалах, мөн Оюу Толгойн нэр төр, эд хөрөнгийг хамгаалах зорилготой юм.

Хэд хэдэн цуврал уулзалтуудыг 2011 онд явуулсан<sup>27</sup> бөгөөд үүнд *Олон нийтийн нээлттэй өдрийг* зохион байгуулсан ба энэ үеэр Оюу Толгой төслийн ажилчид, Ханбогд сумын засаг даргатай уулзах үед гомдол санал ирүүлж байсан. Мөн нутгийн иргэдийн төлөөлөл болон СИАЙЭС-н удирдлагууд

<sup>24</sup> CIS (Catering International and Services) нь Францид төвтэй олон улсын байгууллага юм.

<sup>25</sup> Оюу Толгой зөрчлийн үнэлгээ, Рио Тинто Оюу Толгойн дотоод материал, 2010 оны 12 сар.

<sup>26</sup> Оюу Толгойн Аюулгүй байдлын хариу арга хэмжээний төлөвлөгөө 2011 оны 1 сар.

<sup>27</sup> *Бүлэг А6: Олон Нийтийн Хэлэлцүүлэг*-г уулзалт хэлэлцүүлэгүүдийн өдрийг нарийвчилан оруулсан байгаа.

хоорондын уулзалтыг СИАЙЭС-н үйл ажиллагааны талаар тайлбарлах мөн санал гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээлэл өгөх зорилготой зохион байгуулсан. Тодорхой санал гомдлуудыг дурдвал:

- Хөдөлмөрийн хуулийг зөрчих:
  - Олон цагаар ажиллах;
  - Шөнийн ээлж, амралт баяр, эсвэл өвчтэй үед цалин хөлс авахгүй;
  - Эмнэлэгт үзүүлэх чөлөө болон цалинтай чөлөө;
  - Ажилтнуудтай тэгш бус харьцах
  - Ажилд авахад гэр бүлийн ялгаварлал гаргах.
  - Ажилтнуудад цалингийн доод хэмжээнд цалин өгөх;
- Ханбогдын кэмгийн амьдрах нөхцөл муу:хоол хүнс байхгүй;
- Ажлын байрны дарамт шахалт;
- Ханбогд сумын иргэдийн дээд боловсролоос үл хамааран цөөн тооны иргэдийг ажилд авдаг;
- Дүрэмт хувцасны чанар муу,
- Гадаад болон орон нутгийн ажилтнуудад ялгавартай хандах,
- Гол тогооны ажилчид СиАйЭс-ийн ажилтнуудтай ялгавартай хандах,
- Гэр ахуйн ажилтнууд богино хэмжээний завсарлага авахад зориулсан амрах байр хомсдолтой, Сургуулийн болон цэцэрлэгийн хүүхдүүд нь СиАйЭс –ийн ажилчдын хүүхдүүд бөгөөд тэдэнд эцэх эхийн анахарал халамж хэрэгтэй.
- Явуулж болох үйл ажиллагаа – бага хэмжээний олон нийт хамт олны төслийг Ханбогд сумын боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх.

2010 оны сүүлээр хийсэн үнэлгээ болон 2011 оны хэлэлцүүлгээс хойш Оюу Толгой нь СиАйЭс-тай хамтран кэмгийн бие даасан байдлыг сайжруулах болон ажиллах хүчний зөрчлийн эрсдлийг бууруулах зорилгоор олон янзын арга хэмжээг авч байна. Үүнд:

- Кэмгийн бохир усыг өдөр бүр Хойд Кэмгийн бохир цэвэрлэх байгууламж руу хүргэдэг болсон;
- СиАйЭс-ийн удирдлагууд бусад компаниудтай харьцуулсан цалин хөлсний судалгааг явуулж цалингийн харьцаа тэгш зохистой байх нь чухал гэж дүгнэсэн. 1000 ажилчинтай СиАйЭс нь Өмнөговийн бүс болон тухайн орон нутгийн хэмжээнд ч хамгийн том ажил олгогчдын нэг юм. Гол авсан арга хэмжээнээс дурдвал:
  - СиАйЭс-ийн бүх ажилчдын цалингийн судалгааг хийж 2011 оны 4-р сард дуусгасан бөгөөд энэ талар уулзалтын үеэр нотолсон;
  - СиАйЭс-ийн цалингийн системийн нарийвчлан шалгалтын талаар Холбооны төлөөлөгчдөд 2011 оны 2-р 7 хоногт танилцуулсан ;
  - Ажилласан жил болон ажлын гүйцэтгэлээс хамааран бүх ажилчдын цалинг шатлан нэмэх бөгөөд үүнийг цалингийн бүтцэд оруулсан.
  - Ажилчдын авдаг хамгийн доод цалин нилээн бодитой хувиар өссөн.
- Бүх ажилчдын сахилгын мэдээллийг үндэслэн шинэ шударга цалингийн тогтолцоонд шилжсэнээр бүх ажилчид тэгш цалин хөлс авч эхлэх;
- Эдгээр олон нийттэй харилцах албаны ажилтнуудыг СиАйЭс-ийн орон нутгийн ажилчдаас, Англи хэлний сургалт, жижиг бизнес хөгжил (оёдлын газар), болон олон нийт бүлгийн уулзалтын үеэр нэр дэвшүүлэн Олон нийтийн оролцоог сайжруулсан.
- Олон нийт болон ажилтнуудын хэрэгцээг СиАйЭс-ийн дээд удирдлага Захирал, компаний гүйцэтгэх захиралт танилцуулж цаашид авах арга хэмжээний талаар тодруулахыг зорьж байна.

- Хэд хэдэн удаагийн гомдлын дараа Оюу Толгойн үйлчилгээний ажилчдыг нэгдсэн кэмпээс тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үүднээс барилгын кэмп рүү нүүлгэсэн. Түүнчлэн СиАйЭс өөрсдийн ажилчдын амрах байраар хангаж өгөх талаар Оюу Толгойтой хамтран ажиллаж байна.
- Ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх нөхцөл байдалд туслахад чиглэсэн ажилчдын хэд хэдэн асуудлыг дээд удирдлагуудын анхааралд хүрдэн шуурхай хүргээгүй байдал ажиглагдсан. Ийм учраас СиАйЭс нь уурхайн талбай дээр ажиллах боловсон хүчнийхээ тоогоо нэмж тэдний амьдрах байраар ханган, ингэснээр ажилчдын хэрэгцээ шаардлага хүсэлтэнд шуурхай үр дүнтэй хариулах, шийдвэрлэх боломжтой болж байна. Санал гомдол барагдуулах тодорхой журамтай болсоноор Оюу Толгой эсвэл СиАйЭс ажилтаны санал гомдлыг шийдвэрлэх талаар харилцааны тодорхой нууцлал хадгалсан байна.
- СиАйЭс нь ажилчдад зориулсан Англи хэлний сургалтыг явуулж байна. Хяналт, хоол хүнсний эрүүл ахуй, хүний нөөц гэх мэт бусад сургалтуудыг мөн зохион байгуулж байна.
- Амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж бүх гэрүүдэд тус бүрд нь данх өгч, мөн гар бөмбөг болон сагсан бөмбөгийн талбайг байгуулсан. Усанд орох газрын байрыг сайжруулж, өдрийн туршид халуун усны хэмжээг хангалттай байлгахад учирч буй бэрхшээлийг шийдэх талаар ажиллаж байна. Бид саяхан 6-р сард Австрали улсаас засварын инженер урьж авчирсан бөгөөд засвардах шаардлагатай хэсгийг олж тогтоон шаашид засварлах төлөвлөгөөг гаргах үүрэгтэй.
- СиАйЭс нь Ханбогд сумын сургууль гал тогооны иж бүрдэл тоног төхөөрөмж бэлэглэн сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг хэрхэн ашиглах талаар сургалт хийсэн.
- 2011 оны ажилтнуудтай хийсэн зөвшилцөлийн үед СиАйЭс-ийн дүрэмт хувцсаны чанарын талаар хоёр талт тайлангууд байсан учир дүрэмт хувцсанд Оюу Толгойн ууухайн захиргаа үнэлгээ хийсэн. Сайжруулах чиглэлээр гарсан зөвлөмжүүдийг 2012 оны эхээр хэрэгжүүлнэ.

### **Нөлөөллийн бууруулах арга хэмжээ**

Бууруулах арга хэмжээнүүдэд дараах зүйлс багтана:

- Оюу Толгойн ажилд ирэхэд болон гарахад бүртгүүлэх бодлого болон сумын төв рүү зорчих заавар зэргийг багтаасан Оюу Толгой Төслийн Кемпийн Бодлого, Ёс зүйн бодлогоор (2009) дамжуулан ажиллах бүрэлдэхүүнээ хянах хатуу арга хэмжээг хэрэгжүүлдэг. Биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээг баримтлах явдлыг нь тогтмол давтан сургалт, хариуцсан ахлагч нарын хяналт, зөрчсөн тохиолдолд тогтоосон сахилга батын арга хэмжээг авах, мөн Төслийн Санал гомдол барагдуулах журмын дагуу авсан мэдээллийг шалгах замаар хангадаг.
- Барилгын кемпүүдийг малчдын өвөлжөө, бууцнаас хол газарт байршуулах бөгөөд бүх кемп рүү орох, гарах явдлыг хянах болно. Ажиллагсад оройн 6 цагаас хойш эсвэл амралтын үедээ ажлын талбайгаас гарахдаа тусгайлан зөвшөөрөл авах ёстой.
- Төслийн бүх ажилчид уртасгасан цагаар (өдөрт 10-12 цаг), зарим нь шөнийн ээлжинд ажилладаг бөгөөд ажиллагсадтай хийсэн хөдөлмөрийн гэрээний дагуу амралтын өдрүүдтэй байдаг. Амралтын нөхцөл орчноор (спорт зал, спортын талбай, үйлчилгээний байгууламжууд) хангах нь ажилчдыг ажлын талбар дээр байх явдлыг урамшуулж, эрүүл, аюулгүй, барилгын кэмпийн орчинг бүрдүүлэх, урт хугацаанд орон сууцаар хангах зорилготой юм.
- Оюу Толгой нь архи согтууруулах ундааны зохистой хэрэглээг дэмжих болон ажлын байрны гадна зүй бус зан авир гаргахаас сэргийлэхийн тулд Эрүүл Ажлын байрны Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Оюу Толгой төслийн талбайд согтууруулах ундаа зардаг баар байдаг ба үүгээр зөвхөн төслийн ажилчид үйлчлүүлэх эрхтэй. Согтууруулах ундааны хэрэглээг нарийн хянадаг бөгөөд өндөр градустай согтууруулах ундаа зардаггүй. Баарнаас согтууруулах ундааг авч гарахыг зөвшөөрдөггүй бөгөөд баарны үйл ажиллагаа оройн 21 цагаас зогсдог. Ажлын байранд архидан согтуурахыг хориглодог бөгөөд аймгийн удирдлагаас тогтоосон журмын дагуу Лхагва гаригт төслийн талбайд согтууруулах ундаагаар үйлчлэхгүй.

- Оюу Толгойн хүний нөөцийн бодлого нь гэр бүлд чиглэгдсэн, орон нутгийн ажиллагсдад зохицсон байдаг. Оюу Толгой нь гарч байгаа хүсэлтүүдийн дагуу орон нутгийн ажилчдын ажил амралтын хуваарьт өөрчлөлт оруулсан бөгөөд ингэснээрээ тэд гэр бүлтэйгээ илүү цаг зарцуулах болсон;
- Монгол болон гадаадын ажиллагсдад зориулсан соёлын хөтөлбөрийг хэрэгжүүлж, бүх ажилчид, зочид орон нутгийн иргэдийн талаар болон тэдэнд тэдний үүргийн талаар бүрэн танилцуулга, мэдээлэл өгнө. Оюу Толгой нь энэхүү шаардлагуудыг хэрэгжүүлэхийг гэрээт гүйцэтгэгч компаниудаасаа шаардах бөгөөд орон нутгийн иргэдийн дотор ажиллах хүчний зан байдлыг байдлыг хянана;
- Эмэгтэй үйлчлэгч нар бэлгийн дарамтанд орох явдлаас сэргийлэхийн тулд хэрэв шаардлагатай гэж үзвэл хамгаалалтын албаар хамгаалуулна. Цэвэрлэгээг боломжтой бол тухайн байгууламжуудыг хоосон үед явуулах бөгөөд бэлгийн дарамт үзүүлсэн тохиолдолд ажлаас халах хүртэл арга хэмжээ авах тухай бодлогыг таниулж мэдэгдэнэ.
- Төслийн ажилчдаас үүдэн хувь хүмүүсийн аюулгүй байдалд учрах асуудлыг хянах Санал гомдол барагдуулах журмыг<sup>28</sup> хэрэгжүүлнэ, Авч байгаа бүх арга хэмжээ нь орон нутгийн иргэд, сум, аймгийн удирдлагуудтай явуулсан хэлэлцүүлэг дээр үндэслэгддэг. Оюу Толгой нь гол ханган нийлүүлэгчид зэрэг ажиллах хүчний зан байдалтай холбоотой үүссэн орон нутгийн иргэдийн аливаа гомдол саналд хариу арга хэмжээ авах болно. Оюу Толгой нь нутгийн удирдлагуудад Ханбогд суманд болон бусад шинээр хүн ам суурьших газарт найдвартай орон сууц, аюулгүй байдал, зохих гэрэлтүүлэг болон бусад холбогдох арга хэмжээ авагдсан эсэхэд туслалцаа үзүүлэх болно.
- Төсөл нутгийн ёс зүйн хэм хэмжээ, соёлд нийцүүлж биеэ авч явахыг бүх ажилчдад уриалж, дэмжиж ажилладаг.
- Оюу Толгой нь орон нутгийн иргэд ба төслийн ажилчдын хооронд үүсч болзошгүй маргаан зөрчилдөөнөөс сэргийлж нутгийн иргэд болон гадны ажилчдын хооронд харилцаа үүсэхболомжийг бууруулахыг зорьж байна. Гол кемпүүд сумын төвөөс зайтай байрлах бөгөөд зориулалтын бүх байгууламжууд уурхайн талбайд байрладаг тул тулажилчид төслийн талбайд амралт, чөлөөт цагаа өнгөрөөх боломжтой болсон. Ханбогд сумын төвтэй ойролцоо суурьшдаг СиАйЭс үйлчилгээний албаны хүмүүс нутгийн иргэдтэй харьцах явдал түгээмэл юм. СиАйЭс-н кемп нь Ханбогд сумын төвөөс 500 орчим метрийн зайд оршино. Тус кемпийн ажилчдын олонхи нь Ханбогд сумын иргэд бөгөөд чөлөөт цагаараа сумын төв рүү явган явах боломжтой боловч харуул хамгаалалт алба кемп рүү зөвшөөрөлгүй нэвтрэх явдалд хяналт тавьж ажилладаг. Энэ тохиолдолд ажилчид Ёс зүйн байдлын дүрмийг дагаж мөрдөнө.
- Осол болон гэнэтийн явдалд авах арга хэмжээнүүдийг *Онцгой байдал ба хариу авах арга хэмжээний төлөвлөгөөнд* авч үзсэн.

Ажиллах хүчний менежментийн талаарх дэлгэрэнгүйг *D17: Ажиллах хүчний менежментийн төлөвлөгөө* бүлэгт орсон.

Оюу Толгой нь архийг зүй зохистой хэрэглэх, сэтгэцийн эрүүл мэнд, амиа хорлох явдлаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр, хоол тэжээл, биеийн тамир, хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг олон тооны арга хэмжээнүүдийг дэмжих/хөнгөвчлөхийн тулд орон нутгийн эрүүл мэндийн албадуудтай хамтран ажиллах болно. Ханбогд суманд эрүүл мэнд болон сайн сайхан аж байдлыг хөхүүлэн дэмжих компани ажилд малчдыг, тухайлбал эмэгтэйчүүд, хүүхдүүд зэрэг бусад эмзэг бүлгүүдийг татан оролцуулах явдлыг хангахад гол анхаарал тавих юм.

Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор шилжин ирж байгаа хүн амын тооноос үзвэл төслийн барилгын шатанд Ханбогд болон Даланзадгад сумын эмнэлгийн ажилтнуудын орон тоог нэмэх шаардлагатай байна. Оюу Толгой нь орон нутгийн удирдлагуудтай эдгээр өсөн нэмэгдэж буй эрэлт шаардлагыг хангах арга замын талаар ярилцаж байгаа бөгөөд орон нутагт эрүүл мэндийн дараах арга хэмжээнүүдийг санаачлан хэрэгжүүлсэн: Өмнөговь аймагт мэргэшсэн 14 эмчийг урьж ажиллуулах тэтгэлэгт хөтөлбөр, Ханбогд суманд шүдний эмнэлэг нээх болон аймгийн хэмжээнд

<sup>28</sup> Санал гомдол барагдуулах журмыг *Бүлэг D14: Оролцогч ба сонирхогч талуудын оролцооны төлөвлөгөөнд* хавсаргасан.

эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвүүд байгуулах мөн Жавхлант багийн төвд гэмтлийн төв байгуулах зэрэг орно. Хүн амын тоо болон насны бүтцэд өөрчлөлт орох зэрэг нь эмнэлгийн түргэн шуурхай үйлчилгээ ба томоохон ослын үед шаардлагатай яаралтай тусламжийн эрэлтийг нэмэгдүүлнэ.

Оюу Толгой нь мөн орон нутгийн засаг захиргаа, төрийн бус болон олон нийтэд тулгуурласан хамтрагч /түншүүд/ нараараа дамжуулан хүний наймаатай холбоотой асуудлуудыг хянах болно. Хэрэв төслийн үйл ажиллагааны улмаас хүн амын шилжилт хөдөлгөөн болон бусад шууд бус үр дагавартай холбоотойгоор ямар нэгэн асуудал үүсвэл Оюу Толгой нь дотоодод болон хил дамнуулан хүн худалдаалах гэмт хэргийн эрсдлийг бууруулахад өөрийн зүгээс шаардагдах тодорхой арга хэмжээнүүдийг тодорхойлох болно.

### **Нөлөөллийн зэрэглэл**

Хүн ам шилжин суурьших явдал нэмэгдсэнтэй холбоотойгоор гэмт хэргийн өсөх мөн хувь хүний аюулгүй байдалд эрсдэл учрах **магадлал** улам ихэсч байна. Гэхдээ эдгээр нь бүгд Оюу Толгой төсөлтэй холбоотой биш байж болох бөгөөд нөлөөлөл нь **дунд хугацааны, орон нутгийн шинжтэй** байна. Ажиллах хүчний менежмент болон бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр хувь хүний аюулгүй байдал ба эрүүл мэндэд **дунд зэргийн сөрөг** нөлөөлөлтэй нь байна. . Урт хугацаанд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа зэрэг бүс нутгийн нийгмийн хамгааллын үйлчилгээнүүд сайжирч, хүмүүс амьдралын шинэ хэв маягт дасан зохицсоноор нөлөөлөл нь **бага зэрэг сөрөг** болж буурах юм.

### **12.3.7 Олон нийтийн эрүүл мэндэд барилгын болон ашиглалтын шатанд үүсэх нөлөөлөл: Тоосжилт**

#### **Нөлөөллийн тодорхойлолт**

Ханбогд суманд голлон давамгайлж байгаа өвчлөл нь 2007 онд амьсгалын замын өвчлөл, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл, бэлгийн болон шээсний замын системийн өвчлөл ба цусны эргэлтийн системийн өвчлөл зэрэг байсан<sup>29</sup>. Хучилт хийгээгүй замын тоосжилтод малчид ихээхэн өртөж байгаа бөгөөд Оюу Толгой компанийн хүмүүстэй хийсэн хэлэлцүүлгийн үеэр зам барилгын ажил болон тоос шорооны улмаас малаа хол нүүлгэн бэлчээх шаардлагатай болсон тухайгаа ярьж байсан. Хээрийн судалгааны багийн судалгаанд оролцогчдын мэдээлснээр нядлагдсан малын уушиг бохирдсон байсан ажээ<sup>30</sup>. Тус суманд амьсгалын замын өвчлөл нэгэнт өндөр байгаа тул, Ханбогд суманд нэмж барилгын ажил явуулах, замын хөдөлгөөн нэмэгдэх зэрэг нь амьсгалын замын өвчлөлийг улам хурцатгах буюу (арьсны харшил, нүд үрэвсэх гэх мэт) өөр шинэ нөхцөл байдлыг бий болгож болох юм.

УЛТ-н орчимд одоогоор тоосжилт үүсгэх эх үүсвэр нь замаар явж байгаа тээврийн хэрэгсэл болон барилгын ажлаас үүсч байгаа тоосжилт зэргээр хязгаарлагдаж байна. Уурхайн лицензит талбайн орчмын 10 км-н зайд малчин иргэдийн өвөлжөө бууц байршуулахгүй байх хориотой бүс тогтоосон гэвч уурхайн талбай дээр явагдаж буй үйл ажиллагаанаас ялгарах тоосжилт зуны улиралд хориотой бүсд нутаглаж буй айл өрхүүдэд нөлөөлж болзошгүй (*Бүлэг С10: Газар ашиглалт, нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл-г үзнэ үү*).

УЛТ, нисэх онгоцны буудлын талбай, Гүний Хоолойн ус дамжуулах шугам зэрэг барилгын үйл ажиллагаа явагдаж байгаа талбайн тоосжилт нь түр зуурынх байх бөгөөд усалгаа болон талбай дээрх бусад инженерийн арга хэмжээнүүдээр зохицуулагдаж байна. Орон нутаг болон нийгмийн асуудал эрхэлсэн хэлтэс барилгын үйл ажиллагаа явагдах шинэ талбайн талаар малчдад мэдэгдэх бөгөөд ингэснээрээ барилгын ажил явагдаж байх хугацаанд тоосжилт болон дуу чимээний нөлөөнөөс зайлсхийх боломжтой юм.

Оюу Толгой төслийн зам барилгын болон ашиглалт нь Өмнийн Говийн бусад замуудын адил хуримтлагдсан тоосжилтын эх үүсвэр боловч тээврийн хэрэгслээс ялгарах хийний хувьд бага байх юм. Ханбогд сумын хувьд нүүрс зөөвөрлөдөг зам нь 2011 онд уг замыг сайжруулах хүртэл

<sup>29</sup> Оюу Толгой төслийн *Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөл байдлын үнэлгээ*, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум 2011.

<sup>30</sup> *Ibid*, Оюу Толгой төслийн *Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлөл байдлын үнэлгээ*, Хөх Тэнгэр Хөгжил Консорциум 2011.



тоосжилтын томоохон эх үүсвэр болж малчидаас гомдол санал их ирдэг байв. Энэ зам нь одоо хучилттай болсон. Хатуу хучилтгүй олон салаа замаар төслөөс бусад хэрэглэгчид зорчих явдал нь Ханбогд суманд тоосжилт үүсгэж буй бас нэгэн эх үүсвэр юм. Оюу Толгой-Гашуун Сухайт чиглэлийн шороон замыг ашиглаж эхэлсэн нь Ханбогд сумын тоосжилтын түвшинд нөлөөлж байсан боловч 2011/12 онд тус замыг сайжруулж хатуу хучилттай болгож байгаа бөгөөд үүнээс үүсэх аливаа тоосжилт түр зуурынх юм. Оюу Толгой төслийн улсын хил хүртэлх зам дагуу нутаглаж буй малчидтай тоосжилт болон замын бусад нөлөөллийн талаар олон удаагийн хэлэлцүүлэг хийсэн бөгөөд барилгын ажлын явцад тоос, дуу чимээнээс зайлсхийх, амьжиргаагаа хэвээр авч үлдэх тал дээр малчдад туслалцаа үзүүлсэн.

Төслийн хүрээнд баригдах эрчим хүч дамжуулах шугамын засвар үйлчилгээний шороон зам болон Гүний Хоолойн ус дамжуулах шугамын засвар үйлчилгээний замын ашиглалт нь бага хэмжээний тоосжилт үүсгэх эх үүсвэр болох боловч өдөрт явах тээврийн хэрэгсэл 1-2-оор хязгаарлагдах тул нэмэлт тоосжилт маш бага түвшинд байхаар байна.

Хангамж, тээврийн үндсэн зам болон ашиглагдах Мандалговиос УБ хүртэлхи зам нь төслийн барилгын болон ашиглалтын явцад тоосжилтын эх үүсвэр болох хэдий ч замын хөдөлгөөнийг оновчтой менежментийн үр дүнд үүсэх нөлөөлөлийн хэмжээ нь буурна. Энэхүү замаар зорчих төсөлд хамааралгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлагдмал тул хуримтлагдах нөлөөлөл бага байх бөгөөд энэ нь Манлай сум зэрэг суурингуудад хамгийн ихээр мэдэгдэх болно. Энэхүү суурин газруудаар дамжин өнгөрөхдөө зам дагуу хурдны зохих хязгаарыг тогтоосноор энэхүү нөлөөллийг бууруулж чадна.

#### **Нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

Оюу Толгой нь Оюу Толгой-Гашуун Сухайтын чиглэлийн замыг сайжруулж, давхар хучилт хийх бөгөөд ингэснээр замын тогтсон чиглэл гарч, замгүй газраар зам гаргаж давхих явдлыг мөн тоосжилтын хэмжээг бууруулна. Энэхүү зам нь тооцоолж буй хөдөлгөөний ачаалал болон тээврийн хэрэгслүүдийн овор хэмжээнд тохирсон аюулгүй байдлыг хангаж чадахуйц даацтай байна. Мөн Оюу Толгой нь төсөлд ихээр ашиглагдаж байгаа Оюу Толгойгоос Ханбогд хүртэлхи зам гэх мэт бусад зам засварын ажилд хувь нэмэр оруулж, туслах болно. Тоосжилтыг бууруулах тодорхой арга хэмжээнүүдийг *Бүлэг D2: Агаарын чанарын менежментийн төлөвлөгөө*-нд тодорхойлсон.

#### **Нөлөөллийн зэрэглэл**

Оюу Толгой-Гашуун Сухайтын чиглэлийн зам барих, ус дамжуулах шугам тавих, хөрс хуулах, газар цэвэрлэх бусад газар шорооны ажилаас тоосжилтын түвшин нэмэгдэх нь **зайлшгүй**. Энэхүү нөлөөлөл нь **орон нутгийн шинжтэй, богино хугацаанд**, үргэлжилнэ.

. Амьсгалын замын өвчлөлийн тохиолдол өндөр түвшинд байгаа тул Оюу Толгой-Гашуун Сухайтын замд хучилт хийж дуусах хүртэл энэхүү нөлөөлөл нь **дундаж сөрөг түвшинд** байхаар байна. Урт хугацаанд карьеруудыг нөхөн сэргээж, ОТ-ГС-ын замд хучилт хийгдэж, барилгын ажил дууссан байх тул энэхүү нөлөөлөл нь **бага сөрөг түвшинд** хүртэл цаашилбал илүү буурах юм.

### **12.3.8 Барилгын болон Ашиглалтын Шатны Үйл Ажиллагаа Олон Нийтийн Эрүүл Мэндэд Нөлөөлөх: Дуу Чимээ**

#### **Нөлөөллийн тодорхойлолт**

Төслийн барилга болон замын ажил, түүнчлэн тэсэлгээний ажлаас үүсэх дуу чимээ нь тухайн газрын малчид болон зэрлэг амьтдад тодорхой хэмжээний нөлөө үзүүлнэ.

#### **Бууруулах арга хэмжээ**

Оюу Толгой төсөл нь нутгийн иргэдэд төслийн барилгын болон ашиглалтын шатанд үүсэх дуу чимээний нөлөөллийг бууруулах тал дээр ажиллах болно. Дуу чимээг бууруулах олон янзын арга хэмжээнүүдийг ашиглах болно. Нутгийн иргэдэд тэсэлгээний ажлын талаар урьдчилан мэдэгдэж, тэсэлгээний ажлын цагийг хүмүүст хамгийн бага мэдрэгдэх үед байхаар сонгоно. б (жишээлбэл, өдрийн цагаар). Бууруулах арга хэмжээний дэлгэрэнгүйг *Бүлэг D18: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө*-д үзүүлсэн.

### **Нөлөөллийн зэрэглэл**

Уурхай барилгын болон тэсэлгээний ажлаас шалтгаалан дуу чимээний хэмжээ зайлшгүй нэмэгдэнэ. Гэвч энэ нөлөөлөл нь урт хугацааны боловч орон нутгийн шинжтэй байна. Уурхайн орчмын 35 км дотор суурьших хүн амын хэмжээ бага байх тул нөлөөлөлийн хэмжээ бага зэрэг сөрөг байна гэж таамаглаж байна.

### **12.3.9 Барилгын болон Ашиглалтын Шатны Үйл Ажиллагаа Олон Нийтийн Эрүүл Мэндэд Нөлөөлөх: Усан Хангамж болон Усны чанар**

#### **Нөлөөллийн тодорхойлолт**

Нутгийн иргэдийн амьдралд нөлөөлөх усан хангамж болон чанарын олон нөлөөллүүд байна. Үүнд:

- Гүний Хоолойн газар доорхи усыг шавхах
- Малчдын гар худгийг шавхах
- Булаг шанд ширгэх
- Хаягдал шингэн хадгалах байгууламж болон Хаягдал чулуулгийн овоолго халих болон бусад ослоос гүний ус бохирдох зэрэг болзошгүй нөлөөлөл байна.

Усанд нөлөөлөх нөлөөллийн дэлгэрэнгүйг Бүлэг С5: Усны нөөц бүлэг-с харна уу.

#### **Нөлөөллийн бууруулах арга хэмжээ**

Оюу Толгой төсөл нь орон нутгийн иргэдийн усан хангамж болон чанарт нөлөөлөх байдлыг бууруулах тал дээр Усны Нөөцийн Менежментийн Төлөвлөгөө ба Аюултай Материалын Менежментийн Төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар ажиллах болно. Оюу Толгой төсөл нь Оролцоон дээр түшиглэсэн Хяналт Шинжилгээний Хөтөлбөрийг нөлөөлөлд өртөх магадлалтай орон нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх бөгөөд энэ нь малчдын худгийн усны түвшин ба чанарын хяналт шинжилгээ нээлттэй хийгдэх мөн хоёр талын хооронд итгэлцэл бий болгох зорилготой юм. Хэрэв асуудал тодорхойлогдвол Оюу Толгой төсөл нь нөлөөлөлд өртсөн малчидтай харилцан зөвшилцөж тохиролцсон шийдэл арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх ба хянахын тулд хамтран ажиллана (тухайлбал шинээр гүний худаг гаргаж өгөх замаар усны шинэ эх үүсвэр гаргаж өгөх гэх мэт). Ийм арга хэмжээнүүд энгийн бөгөөд хэрэгжүүлж болохуйц юм.

Усны талаар нөлөөллийг бууруулах арга хэмжээний дэлгэрэнгүйг Бүлэг С5: Усны нөөц-д үзүүлэв.

### **Нөлөөллийн зэрэглэл**

Усан хангамжинд гарах өөрчлөлт нь цогц асуудал бөгөөд яригдаж буй уст давхарга бүрээс шалтгаална. Нөлөөллийн магадлал нь зайлшгүйгээс магадгүй хүртэл, богино хугацаанаас байнгын хүртэл янз бүр байна. Гэвч бүгд орон нутгийн шинжтэй. Нөлөөллийн зэрэг нь маш багаас дунд зэрэг сөрөг хүртэл хэлбэлзэнэ. Усны чанарт гарах өөрчлөлт магадлалгүй, орон нутгийн шинжтэй, богино хугацааны ба бага зэрэг сөрөг байна. Дэлгэрэнгүйг Бүлэг С5: Усны нөөц-с үзнэ үү.

## **12.4 ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ**

Оюу Толгой төслийн олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын үлдэгдэл нөлөөллийг дараахь байдлаар тодорхойлж болно:

- Ханбогд сумын ойр орчмын оршин суугчид, бусад зам ашиглагчдад ялангуяа Оюу Толгой-Гашуун Сухайтын замд тээврийн осол ихсэх бодит магадлал болон замын аюул ихсэх магадлал. D11: Зам тээврийн менежментийн төлөвлөгөөнд тодорхойлсноор жолооны сургалтууд, орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх аянг өрнүүлснээр замын аюулгүй байдлыг зохицуулж болно;
- Нисэх буудлын талбай, Гүний Хоолойн ус дамжуулах шугам, цооногийн талбай, цахилгаан дамжуулах шугам зэрэг төслийн байгууламжуудад барилгын ажил явагдаж байх хугацаанд ойр орчмын малчдад төслөөс үүдэн учирч болох аюул; гэвч энэхүү аюул нь түр зуурын шинжтэй бөгөөд барилгын ажлын үе шатаар хязгаарлагдана;

- Барилгын томоохон ажиллах хүч орж ирсэний улмаас халдварт өвчний тохиолдол ихсэх магадлалтай. Гэвч ажилчдыг орон нутгийн иргэдтэй харьцах талаар хатуу хяналт бүхий кемпэд голлон байрлуулна;
- Хүн амын шилжилт хөдөлгөөний улмаас гэмт хэрэг, архидалтай холбоотой өвчин болон тохиолдлууд өсөх хандлагатай. Гэвч орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг бэхжүүлэх, орон нутгийн иргэдэд мэдлэг олгох сургалт хийх, ажиллах хүчний дүрэм журмыг чанд мөрдсөнөөр үүнийг зохицуулах юм;
- Барилгын ажлын явцад үүссэн тоосжилт нь ойролцоох оршин суугчдад богино хугацаанд тодорхой нөлөөлөл үзүүлж, амьсгалын замын өвчлөл болон бусад нөхцлүүдийг сэдрээж болох юм. Цаашид ашигт малтмалын баяжмал тээвэрлэх замд давхар хучилт хийж, төслийн үйл ажиллагаа болон орон нутгийн суурин газруудын хооронд зохих тусгаарлалтын орон зайг бий болгосноор төслөөс үүдэн бий болох тоосжилтын нөлөөллийг бууруулах юм.

Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын бусад хэсгүүдийг урт хугацааны туршид хэрэгжүүлэх Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын хөтөлбөр (ОНЭМАААБХ)-ийг хэрэгжүүлэх замаар зохицуулан хянах бөгөөд үүнд, орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх аянг явуулах, нийгмийн дэд бүтцийг дэмжих болон шаардлагатай үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг бэхжүүлэх зэрэг багтана.

Түүнчлэн Оюу Толгой нь D16: Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөө болон томоохон барилгын ажиллах хүчинд нөлөөлөх байдлыг бууруулах, нүүлгэн шилжүүлэлтийг хязгаарлахад чиглэгдсэн стратеги болон хөтөлбөрүүдийг боловсруулан гаргасан.

Тоосжилтын менежмент нь Төслийн бүст олдоц багатай, үнэ цэнэтэй ихээхэн хэмжээний усыг ашиглан үр дүнтэй тоосжилтын менежментийг шаарддаг. Үүний үр дүнд усыг нөөцөлснөөр төслийн ойролцоох 10 км-т оршин суухыг хориглосон бүсийн орчимд тоосжилтыг бууруулах хэрэгцээг тэнцвэржүүлэхийг зорьсон

Доорх Хүснэгт 12-1-д Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын болзошгүй нөлөөллүүдийн хураангуйг үзүүлэв.

Хүснэгт 12-1: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллүүд

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төлөвлөлт, Сайжруулалт ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
Замын аюул осол нэмэгдэх	Малчид, орон нутгийн болон бүс нутгийн оршин суугчид	Барилга Ашиглалт	<b>Үргэлжлэх хугацаа</b> Урт хугацааны <b>Хамрах хүрээ</b> Орон нутгийн <b>Магадлал</b> магадлалтай	Ноцтой сөрөг нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> <li>Оюу Толгой-Гашуун Сухайтын замыг сайжруулах, давхар хучилт хийх. Тээврийн хэрэгслийн зохих овор хэмжээ, хөдөлгөөний ачаалалд тулгуурлан замын зураг төслийг гаргах.</li> <li>Төсөлд ихээр ашиглаж байгаа замуудад засвар үйлчилгээ, шаардлагатай замын тэмдэг тэмдэглэгээг хийх</li> <li>Жолоочийг дүрэм журмын дагуу жолоодож байгаа эсэхийг сансрын төхөөрөмжөөр хянах, хурд хянах төхөөрөмжийг ашиглах</li> <li>Зам дээр болон замын ойролцоо амьтан ажиглагдах үед хэрхэн жолоодох талаар ойлголтыг оруулсан аюулгүй жолоодлогын сургалт зохион байгуулах Үүнд, <ul style="list-style-type: none"> <li>Зам дээр болон замын ойролцоо амьтан (таван хошуу мал эсвэл зэрлэг) ажиглагдах үед хэрхэн жолоодох талаар тодорхой журмыг багтаасан сургалт зохион байгуулах</li> <li>Жолоочийн сургалтанд олон нийтийн эрсдлийн талаар оруулж, хурдны хязгаарлалтыг хэрэгжүүлэх</li> <li>Аялалын тогтоосон цагийг мөрдөх, амрах хугацааг хэрэгжүүлэх. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>Өдрийн аялалын дээд цагийг 9-н цагт багтаах (7 хоногт 2 удаа 10 цаг хүртэл )</li> <li>7 хоногт хамгийн ихдээ 56 цаг жолоо барих (2 долоо хоногт 90 цагаас багагүй)</li> </ul> </li> </ul> </li> </ul>	Тээврийн менежментийн төлөвлөгөө Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын төлөвлөгөө Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын хөтөлбөр Оролцогч ба сонирхогч талуудын оролцооны хөтөлбөр	Дунд зэргийн сөрөг нөлөөлөл

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төлөвлөлт, Сайжруулалт ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
					<ul style="list-style-type: none"> <li>▪ 4.5 цаг тутамд зогсож амрах</li> <li>▪ Төсөл нь согтууруулах ундааны эсрэг хатуу бодлогыг баримталж хэрэгжүүлнэ</li> <li>▪ Бүх жолооч нарт онцгой байдлын үед авах журмын талаар сургалт хийнэ</li> <li>▪ Жолоодлого болон аялалыг аль болох өдрийн цагаар хийх. Амьтны зам дээр үзэгдэх боломжтой гарцуудыг тэмдэглэж, жолоочид сануулах зорилгоор зохих тэмдэг тэмдэглэгээг тавих. Уулзвар, замын зөрлөгийг тэмдэгжүүлэн, зам тавьж өгөх талыг тодорхой зааж өгөх.</li> <li>▪ Аюултай, хортой материалыг аюулгүй тээвэрлэх тухай журмыг мөрдөх, тухайлбал, онцгой байдлын үед хариу авах арга хэмжээний шаардлагыг багтаах.</li> <li>▪ Тээврийн гэрээт гүйцэтгэгч компаниуд онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй байна; Оюу Толгой тээврийн гэрээт гүйцэтгэгч компаниудад тогтмол аудит хийнэ.</li> <li>▪ Орон нутгийн иргэд болон зам дагуу нутагладаг суурингуудад Замын хөдөлгөөний талаар мэдлэгийн нэмэгдүүлэх зорилготой дэлгэрэнгүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх</li> <li>▪ Онцгой нөхцөл байдал/эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт хийх. Жишээлбэл, түргэн тусламж, гэмтлийн төв гэх мэтэд.</li> </ul>		

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төлөвлөлт, Сайжруулалт ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
Олон нийт төслийн үйл ажиллагааны аюулд өртөх	Малчид, бусад орон нутгийн иргэд	Барилга Ашиглалт Уурхайн хаалт	<b>Үргэлжлэх хугацаа:</b> Урт хугацааны <b>Хамрах хүрээ</b> Зөвхөн орон нутгийн <b>Магадлал</b> магадлалтай	Дунд зэргийн сөрөг нөлөөлөлтэй	<ul style="list-style-type: none"> <li>Зөвхөн зөвшөөрсөн бүс нутгуудад үйл ажиллагааг явуулах, барилгын талбайд тодорхой хил зааг тогтоож, тэмдэгжүүлэх</li> <li>Барилгын кемпүүдийг хөдөөгийн малчдын өвөлжөө, бууцнаас хол бүсэд байрлуулах, кемпэд орох, кемпээс гарах явдлыг хянах.</li> <li>Барилгын бүсэд очих зам, нэвтрэх шугамыг тодорхойлох, аюулгүй, тодорхой тэмдгүүдийг тавих.</li> <li>Ашиглалтын талбайн эргэн тойронд хашаажуулалт хийх, боломжтой газруудад хамгаалалтын албаныхан оролт, гаралтыг хянах.</li> <li>Олон нийттэй харилцах албаныхан төслийн болзошгүй аюул болон өөрчлөгдөж байгаа үйл ажиллагааны талаар малчидад болон бусад иргэдэд тогтмол мэдээлэл өгч байх.</li> <li>Тухайн бүсэд явагдах бүх барилгын ажлын талаар ойр орчмын бүх иргэдэд урьдчилан мэдээдэл өгч байх.</li> <li>Уурхайг хаалтын үед машин, тоног төхөөрөмж болон аюултай материалуудыг зайлуулах ба ил уурхай/бусад аюултай газруудыг олон нийт нэвтрэхээс хамгаална.</li> </ul>	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын төлөвлөгөө Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын хөтөлбөр Оролцогч ба сонирхогч талуудын оролцооны хөтөлбөр Уурхайн хаалтын болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөө Онцгой байдлын бэлэн байдал болон хариу авах арга хэмжээний төлөвлөгөө	Бага сөрөг
Халдварт өвчний тохиолдол ихсэх	Орон нутгийн болон бүс нутгийн иргэд	Барилга Ашиглалт	<b>Үргэлжлэх хугацаа</b> Урт хугацааны <b>Хамрах хүрээ</b> Орон нутгийн	Дунд зэргийн сөрөг нөлөөлөлтэй	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын явцад ихэнх ажигчид кемпэд амьдрах ба олон нийттэй харьцах явдал хяналтанд байна. Кемпэд ажилладаггүй гадны хүнийг байлгахгүй.</li> <li>Олон нийттэй харьцах, мансууруулах бодис, биеэ үнэлэх явдлын эсрэг дүрэм журмыг</li> </ul>	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын төлөвлөгөө Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Бага сөрөг

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төлөвлөлт, Сайжруулалт ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
			<b>Магадлал</b> магадлалтай		<p>багтаасан ажилтны дагаж мөрдөх ёстой ёс зүйн дүрмийг хэрэгжүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>Ажилчдыг эрүүл мэндийн бүрэн үзлэг оношлогоо, эрүүл мэндийн байнгын үзлэгт хамруулна.</li> <li>Орон нутгийн иргэд, ажиллагсдад БЗХӨ/ХДХВ-ийн талаар мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх.</li> <li>Төслийн Нөлөөллийн бүсэд халдварт өвчнүүдийн үндэсний хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцоно.</li> <li>Эрүүл мэндийн үйлчилгээ, эмнэлгийн байгууллага, тоног төхөөрөмж, эмнэлгийн ажиллагсдыг сургалтанд хамруулах зэрэгт хөрөнгө оруулалт хийнэ.</li> </ul>	болон аюулгүй байдлын хөтөлбөр Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө	
Хамгаалалтын албаны үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой эрсдэлүүд	Малчид, бусад орон нутгийн иргэд	Барилга Ашиглалт Уурхайн хаалт	<b>Үргэлжлэх хугацаа:</b> Богино хугацааны <b>Хамрах хүрээ</b> Зөвхөн орон нутгийн <b>Магадлал</b> магадлалтай	Бага зэрэг сөрөг нөлөөлөлтэй	<ul style="list-style-type: none"> <li>Аюулгүй байдлын болон хүний эрхийн сайн дурын зарчмууд дээр үндэслэсэн аюулгүй байдлын үйл ажиллагааг явуулна.</li> <li>Хамгаалалтын ажилтанууд/албаныханд бүрэн үнэлгээ явуулна. Оюу Толгой нь хамгаалалтын ажиллагсдад хөндлөнгийн хяналт явуулна.</li> <li>Оюу Толгойн ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч компаниудад хүний эрхийн талаар танилцуулга сургалт явуулна. Хамгаалалтын үйлчилгээ үзүүлэгчдийг өөрийн ажилтнууддаа хүний эрхийн талаар сургалт явуулахыг дэмжих.</li> <li>Хамгаалалтыг удирдах болон Хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг</li> </ul>	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын төлөвлөгөө Аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө Хамгаалалтын ажилтануудын хүч хэрэглэх явдалд тавих хяналтын журам	Магадлалгүй

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төлөвлөлт, Сайжруулалт ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
					<p>хэрэгжүүлэх зорилго бүхий багийг /ажлын хэсгийг/ бүрдүүлнэ. Олон нийттэй болон ажиллагсадтай аюулгүй ажиллагааны бүх асуудлаар харьцах Оюу Толгойг төлөөлөх ахлах Монгол даргыг томилно.</p> <ul style="list-style-type: none"> <li>Хамгаалалтын ажилтнуудын хүч хэрэглэх тал дээр хяналт тавих журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ.</li> <li>Хамгаалалттай холбоотой хэрэг зөрчил дээр гаднын оролцогчдыг (жишээлбэл, цагдаа/засаг захиргаанаас) оролцуулна.</li> </ul>		
Хувь хүний аюулгүй байдал, эрүүл мэнд доройтох	Орон нутгийн иргэд	Барилга Ашиглалт	<b>Үргэлжлэх хугацаа:</b> Дунд хугацааны <b>Хамрах хүрээ</b> Орон нутгийн <b>Магадлал</b> магадлалтай	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй	<ul style="list-style-type: none"> <li>Ажил хайж шилжин ирэх хүн амын шилжилт хөдөлгөөнийг бууруулахын тулд ажилд авах журам болон бусад холбогдох журмыг хэрэгжүүлнэ.</li> <li>Үйл ажиллагаанд зориулсан байруудыг барьж Ханбогд суманд ажиллагсадт гэр бүлтэйгээ хамт амьдрахыг дэмжинэ.</li> <li>Үндсэн кемп болон СиАйЭс-н кемп-д хамгаалалтын үйлчилгээг үзүүлэхийг үргэлжлүүлэх.</li> <li>Кемпийн бодлого болон Ёс зүйн дүрмийг мөрдөх.</li> <li>Ёс бус, хууль бус зан авирын эсрэг заалтуудыг багтаасан Сахилгын дүрмийг мөрдүүлнэ.</li> <li>Монгол болон гадаад ажилчдад зориулж соёлын хөтөлбөрийг зохион байгуулна. Оюу Толгой болон гүйцэтгэгч компаниудын ажиллагсад орон нутгийн иргэдийн зүгээс хандах зан байдлын хандлагыг үнэлнэ.</li> </ul>	Хүн амын жилжилт хөдөлгөөний төлөвлөгөө Кемпийн менежментийн журам, Сахилгын дүрэм Оролцогчба сонирхогч талуудын оролцооны хөтөлбөр Онцгой байдалд бэлэн байх болон хариу авах арга хэмжээний төлөвлөгөө	Бага сөрөг



Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төлөвлөлт, Сайжруулалт ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
					<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн иргэдийн санал гомдлын механизмыг хэрэгжүүлнэ.</li> <li>Орон нутгийн засаг захиргаа, төрийн бус түнш байгууллагуудаар дамжуулан хүн худалдаалахтай холбоотой асуудалд хяналт шинжилгээг хийнэ.</li> </ul>		
Тоосжилт ихэссэнээс үүдэн орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө	Орон нутгийн иргэд	Барилга Ашиглалт	<b>Үргэлжлэх хугацаа</b> Богино хугацааны <b>Хамрах хүрээ</b> Орон нутгийн <b>Магадлал</b> Зайлшгүй тохиолдоно	Дунд зэргийн сөрөг нөлөөтэй	<ul style="list-style-type: none"> <li>Оюу Толгой-Гашуун Сухайтын замд давхар хучилт хийнэ.</li> <li>Замыг тогтмол усаар шүршиж тоос шороог дарах арга хэмжээ авна. .</li> <li>Барилгын ажлын явцад тээврийн хэрэгслийн ачаанд хяналт тавина.</li> <li>Тоосжилтын хяналт шинжилгээг хийнэ.</li> </ul>	Агаарын чанарын менежментийн төлөвлөгөө	Бага сөрөг
Дуу чимээ нэмэгдсэнээс үүдэн орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	Нутгийн иргэд	Барилга Ашиглалт	<b>Үргэлжлэх хугацаа</b> Урт хугацааны <b>Хамрах хүрээ</b> Орон нутгийн <b>Магадлал</b> Зайлшгүй тохиолдоно	Баг зэргийн хэмжээтэй сөрөг нөлөө	<ul style="list-style-type: none"> <li>Дуу чимээ бууруулах арга техник ашиглах</li> <li>Нутгийн иргэдэд барилгын ажил болон тэсэлгээний ажлын талаар урьдчилан мэдэгдэх</li> </ul>	Дуу чимээний менежментийн төлөвлөгөө	Бага сөрөг
Усан хангамж эсвэл усны чанарт өөрчлөлт гарах	Нутгийн иргэд	Барилга Ашиглалт	<b>Үргэлжлэх хугацаа</b> Богино	Дунд зэрэг сөрөг нөлөөлөлөөс огт сөрөг	<ul style="list-style-type: none"> <li>Аюултай хортой материалыг зохистой байранд хадгалах, хог хаягдлыг тогмол Оюу Толгойн хаягдлын цэг рүү зөөвөрлөх</li> </ul>	Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө Хортой материалын	Дунд сөрөгөөс магадлалгүй хүртэл хэлбэлзэнэ

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төлөвлөлт, Сайжруулалт ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
			хугацааны, Байнгын <b>Хамрах хүрээ</b> Орон нутгийн <b>Магадлал</b> Зайлшгүй-ээс магадлалгүй хүртэл хэлбэлзэнэ	нөлөөгүй хүртэл хэлбэлзэнэ	<ul style="list-style-type: none"> <li>Гадаргуун усны гольдрол өөрчлөх ажиллагаанд инженерийн нарийн шийдлийг ашиглах, тэр нь бат бэх тогтвортой байх явдлыг хангах мөн гадаргын усны эх үүсвэр доройтохгүй байх, Оюу Толгой төслийн талбайгаартойрч урсах боломжоор хангах</li> <li>Гүний ус ашиглах тохиолдолд тухайн уст давхарга нь малчдын ашигладаг бага гүний уст давхаргаас доош байх, Усыг аль болох хэмнэх</li> <li>Бүрэн жагсаалтыг Бүлэг C5: Усны нөөц-с үзнэ үү.</li> </ul>	менежментийн төлөвлөгөө (Бүлэг D12) болон Хаягдлын менежментийн төлөвлөгөө (D8)	

Тайлбар:

**(1) Анхдагч хүлээн авагчид:** Нөлөөлөлд өртсөн эсвэл бусад сонирхогч оролцогч талуудыг хэлнэ.

**(2) Төслийн үе шатууд:** Барилгын ажил, Ашиглалт, Уурхайн татан буулгалт ба уурхайн хаалт

**(3) Нөлөөлийн ангилал:**

Хугацаа:Богино хугацаа, Дунд хугацаа, Урт хугацаа

Хамрах хүрээ:Зөвхөн орон нутгийн шинжтэй; Орон нутгийн шинжтэй; Өргөн тархсан

Магадлал:Их магадлал багатай; Магадлал багатай; магадгүй; тодорхой

**(4) Нөлөөллийн боломжит зэрэглэл:** Их сөрөг; Дунд зэрэг сөрөг; Бага сөрөг; Өчүүхэн; Эерэг

### Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө [OTESIA@ot.mn](mailto:OTESIA@ot.mn) хаягаар ирүүлнэ үү.